



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУРГАЛТ
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

Ямаатчин
Цогтгэрэл НАРАНГАРАВ

**УЛАМЖЛАЛТ ЗАН ҮЙЛИЙГ АЯЛЛЫН
БҮТЭЭГДЭХҮҮН БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ НЬ**
/Монгол хуримын жишээн дээр/



Мэргэжлийн индекс
041304

Бизнесийн удирдлагын бакалаврын
Зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан
Б. Цогтбаяр \Ph.D\

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУРГАЛТ
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

Ямаатчин
Цогтгэрэл НАРАНГАРАВ

УЛАМЖЛАЛТ ЗАН ҮЙЛИЙГ АЯЛЛЫН
БҮТЭЭГДЭХҮҮН БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ НЬ
/Монгол хуримын жишээн дээр/



Мэргэжлийн индекс
041304

Бизнесийн Удирдлагын Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч : Б. Цогтбаяр\Ph.D\

Зөвлөх : Ч. Болормаа\МВА\

Шүүмж : Б. Мөнхтогтох\МВА\

ГАРЧГИЙН ТОВБЬЁГ

МЭДЭГДЭЛ	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	vi
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	vii
НЭР ТОМБЬЁНЫ ТАЙЛБАР	viii
ОРШИЛ	1
Сэдвийн нэр:	1
Сэдвийн үндэслэл	1
Сэдвийн зорилго, зорилт.....	2
Сэдвийн хамрах хүрээ	2
Судалгааны ажлын таамаглал	2
Сэдвийн судлагдсан байдал.....	2
Судалгааны арга зүй.....	3
Шинжлэх ухаан, практикт оруулах хувь нэмэр.....	3
I БҮЛЭГ. УЛАМЖЛАЛТ ЗАН ҮЙЛ, СОЁЛЫН ДАРХЛАА	4
1.1 Уламжлалт зан үйл, хуримын ёслолын ялгаа, мөн чанар	4
1.1.1 Хуримын ёсон	5
1.1.2 Хуримлах ёсын ялгаа	7
1.2 Хуримын аялал жуулчлалын зах зээлийн боломж	10
1.3 Хуримын аяллын хөтөлбөрийн шинжилгээ	12
1.3.1 Өрсөлдөгчийн шинжилгээ	12
II БҮЛЭГ. ХУРИМЫН АЯЛЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖ	17
2.1 Хуримын аяллын зах зээлийн судалгаа.....	17

2.1.1 Хүн ам зүйн орчин-Дотоодын жуулчин	17
2.1.2 Нийгэм соёлын орчин	21
2.1.3 Хүн ам зүйн орчин-Гадаадын жуулчин.....	22
2.1.4 Хууль эрх зүйн орчин.....	25
2.1.5 Стратегийн төлөвлөлт	26
2.2 Төв халхын хуримын аялал төлөвлөлт	27
2.2.1 Монгол хуримын зан үйлийн дэлгэрэнгүй тайлбар	27
2.2.2 Монгол хуримын дэлгэрэнгүй хөтөлбөрийн төлөвлөгөө	35
2.2.3 Оролцогчдын үүргийн хуваарилалтын менежмент	38
2.3 Хөтөлбөр хөгжүүлэлт ба боломж	40
2.3.1 Хэрэглэгчийн судалгаа.....	40
ДҮГНЭЛТ.....	46
ЗӨВЛӨМЖ.....	47
ХАВСРАЛТ.....	51

МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, эдийн засгийн их сургууль (сээс) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүднээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (cc by-nc-nd) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: Ц. НАРАНГАРАВ

Гарын үсэг:

Огноо: 2026/05/28

ТАЛАРХАЛ

Энэхүү бакалаврын дипломын төслийг гүйцэтгэхэд үнэтэй зөвлөгөө, чиглэл өгч, бүх талаар дэмжин ажилласан удирдагч багш Б.Цогтбаярт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Мөн өөрийн мэдлэг, туршлагаасаа харамгүй хуваалцаж, судалгааны ажилд дэмжлэг үзүүлсэн “Хөх отог” өв соёл хөгжлийн төвийн үүсгэн байгуулагч Ж.Лувсандорж, МУСГЗ, МУСТА, ардын судлаач С.Дамбий нарт гүн талархал илэрхийлье.

Түүнчлэн суралцах хугацаанд минь үргэлж дэмжиж, урам зориг хайрлаж байсан гэр бүл, ангийн хамт олон, эрдэм мэдлэг түгээн зааж, зөвлөж чиглүүлсэн тэнхимийн нийт багш нартаа чин сэтгэлийн талархал өргөн дэвшүүлж байна.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү дипломын ажил нь уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломжийг Монгол хуримын жишээн дээр судлах зорилготой. Судалгаанд уламжлалт зан үйлийн мөн чанар, соёлын дархлаанд гүйцэтгэх үүрэг, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох онолын үндэс, Монгол хуримын ёслолын бүтэц, зах зээлийн боломж, хөтөлбөр боловсруулах арга замыг авч үзэв.

Судалгааны үр дүнд Монгол хурим нь зочдын сонирхлыг татах өндөр соёлын үнэ цэнтэй, танин мэдэхүйн болон туршлагын аяллын бүтээгдэхүүн болгон хөгжих боломжтой нь тогтоогдлоо. Гэвч үүнийг хэрэгжүүлэхэд жинхэнэ ёслолын утга агуулгыг алдагдуулахгүй байх, оролцогч талуудын эрх ашиг, орон нутгийн оролцоо, жуулчны хүлээлт, ёс зүйн асуудлыг оновчтой зохицуулах шаардлагатай байна.

Түлхүүр үгс: *уламжлал, уламжлалт зан үйл, биет бус өв, хуримлах ёс, цээрлэх ёс, хөтөлбөр, аяллын бүтээгдэхүүн, өрсөлдөгч байгууллагууд, халх хурим, аяллын багц.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 Монгол ястны хурим	6
Хүснэгт 1.2 Халх ястны хуримын зан үйлийн ялгаа.....	7
Хүснэгт 1.3 Монгол угсаатны хуримын зан үйлийн харьцуулалт.....	7
Хүснэгт 1.4 Дэлхийн хуримын аялал жуулчлалын ерөнхий үзүүлэлт.....	10
Хүснэгт 1.5 Дэлхийн хуримын аялал жуулчлалын ерөнхий үзүүлэлт.....	11
Хүснэгт 1.6 Монгол Улс дахь хуримын аялал жуулчлалын боломжийн тойм	11
Хүснэгт 1.7 Аяллын бүтээгдэхүүний хувьд Монгол хуримын давуу болон сул тал.....	12
Хүснэгт 1.8 Өрсөлдөгч байгууллагуудын мэдээлэл.....	12
Хүснэгт 1.9 Бүх ангиллыг нэгтгэсэн цогц харьцуулалт.....	14
Хүснэгт 2.1 Монгол Улс дахь хуримын аялал жуулчлалын боломжийн тойм	24
Хүснэгт 2.2 Хууль эрх зүйн орчны шинжилгээ.....	25
Хүснэгт 2.3 SWOT Шинжилгээ - Монгол Хуримын Аяллын Бүтээгдэхүүн.....	26
Хүснэгт 2.4 Монгол хуримын 13 зан үйлийн дарааллын дэлгэрэнгүй	27
Хүснэгт 2.5 Үйл ажиллагааны төлөвлөгөө	35
Хүснэгт 2.6 Аяллын багцын нарийвчилсан зардлын задаргаа.....	37
Хүснэгт 2.7 Дэлхийн destination wedding үнийн харьцуулалт	38
Хүснэгт 2.8 Оролцогчдын үүргийн хуваарилалтын менежмент.....	39

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Монголын хүн амын өсөлтийн диаграмм	4
Зураг 2.1 Гэрлэлтээ бүртгүүлсэн хосуудын тоо /жилээр/	17
Зураг 2.2 Гэрлэлтээ батлуулсан хосуудын тоо /жилээр/	18
Зураг 2.3 Гэрлэлт ба цуцлалтын харьцуулалт	18
Зураг 2.4 Гэрлэлт ба цуцлалтын тоо /жилээр/	20
Зураг 2.5 Гэрлэлтэд эзлэх цуцлалтын хувь	20
Зураг 2.6 МУ-д аялаж буй жуулчдын шалтгаан	23
Зураг 2.7 МУ-д ирсэн жуулчдын тооны харьцуулалт	24
Зураг 2.8 Есөн цагаан тахил	28
Зураг 2.9 Богтос өгөх	28
Зураг 2.10 Сөн нийлэх ёс	28
Зураг 2.11 Монгол гэр	29
Зураг 2.12 Эсгий ширмэл олбог	29
Зураг 2.13 Алаг мэлхий	30
Зураг 2.14 Галын хайч	31
Зураг 2.15 Бэрийн цай чанах ёс	32
Зураг 2.16 Даллагын уут	32
Зураг 2.17 Хишгийн сав	33
Зураг 2.18 Судалгааны ерөнхий мэдээлэл	40
Зураг 2.19 Судалгаанд оролцогчдын хуримын төсөөлөл	42
Зураг 2.20 Судалгааны үйлчилгээ болон зардлын дэлгэрэнгүй	43
Зураг 2.21 Аялал жуулчлал болон соёлын үр дүнг харуулсан хэсэг	44
Зураг 2.22 Монгол хуримын хөтөлбөрийн дэлгэрэнгүй	45

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт А Судалгааны асуулга	51
-------------------------------------	----

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол

СЭЗИС

АЖ

Тайлбар

Санхүү эдийн засгийн их сургууль

Аялал жуучлал

НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР**Нэршил****Тайлбар****Халх**

“Халхавч” гэсэн жинхэнэ монгол үг. Эрт үед “Халх-бамбай” гэсэн цэрэг эрийн биеэ хамгаалах халхавч утгаар нэрлэж байжээ.

Сүй

Монголд гэрлэх ёсонд хүүгийн талаас хүүхний эцэг эхэд өгөх эд зүйлс ба малыг сүй гэнэ.

Найрын 32 ая

Монголын хамгийн урт уянгат аяар дуулдаг айзам 32 дууг найрын 32 ая гэнэ. Үүнд “Түмний эх”, “Дуртмал сайхан”, “Хуурын манлай” зэрэг дууг хүндэтгэлээр дуулдаг.

Тахил

Шарын шашны ёсонд тайх таваглахад хэрэглэх зүйлсийг хэлнэ.

Худ

Эр эм бололцогсдын охины төрхмийн талынх нь хүргэний төрлийн хүмүүсийг ингэж нэрлэдэг.

Бэр

Өөртэй хууль ёсоор гэрлэсэн бусад овгийн эмэгтэй. Хүү, дүү нарын гэргий.

Бэргэн

Ахын гэргий. Ахын эхнэр, биеэс дээших олон үеийнхэн бусад овгоос буулган авсан хөндлөн үеийн эмэгтэйчүүд

ОРШИЛ

Сэдвийн нэр: Уламжлалт зан үйлийн аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх нь /Монгол хуримын жишээн дээр/

Сэдвийн үндэслэл

Монгол улс дэлхийн даяаршил болон хотжих үйл явцад татагдан орж, монголчуудын аж төрөх ёс, монгол хэл, яриа ялангуяа үндэстний цөөнхийн биет бус өвийн үйлдэгдэх орон зай өөрчлөгдөн, орчин цагийн нийтийн соёл, урлаг түрэн орж ирсээр байгаа нөхцөлд “Монголын уламжлалт биет бус соёлын өв, эх хэл, соёл, ахуйн онцлог, аман болон язгуур урлаг, зан үйл, ёслол, баяр наадмыг богино хугацаанд ядууруулж мөхөх байдалд хүргэж болзошгүй юм” хэмээн судлаачид дурдсан байдаг. (ikon.mn, 2016)

Монголчуудын уламжлалт хурим нь гэр бүл, төрөл садан, нийгмийн харилцааг бэхжүүлдэг нэн чухал ёслолын зан үйлийн нэг хэлбэр юм. Энэ ёслол нь зөвхөн хоёр хүний гэр бүл болох үйл явц бус, харин монголчуудын ертөнцийг үзэх үзэл, ёс зүй, хүндлэл, бэлгэдэл, угсаатны өв соёлын илэрхийлэл болдог.

Сүүлийн жилүүдэд соёлын аялал жуулчлалын эрэлт нэмэгдэж, жуулчид зөвхөн үзмэр үзэхээс илүүтэй тухайн орны амьд соёл, оролцоот туршлага, ёслолын утга агуулгыг мэдрэхийг хүсэх болсон.

Дэлхийн олон улс оронд үндэсний онцлог шингэсэн хуримыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж байгаа бол Монгол улсад уламжлалт хуримын ёс заншлыг бүрэн агуулсан, жуулчдад зориулсан зохион байгуулалттай үйлчилгээ одоогоор хангалтгүй байна. Иймд Монгол хуримыг соёлын аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх нь үндэсний өвийг сурталчлах, орон нутгийн эдийн засгийг дэмжих, соёлын дархлааг хамгаалах ач холбогдолтой.

Гэвч уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгоход арилжааны шинж давамгайлах, ёс жаяг алдагдах, нийгмийн зөвшөөрөл сулрах эрсдэл бий. Иймээс энэхүү судалгаа нь Монгол хуримын зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх оновчтой загварыг тодорхойлох шаардлагад тулгуурлана.

Сэдвийн зорилго, зорилт

Монгол хуримын уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зарим боломжийг тодорхойлох.

Зорилтууд

1. Уламжлалт зан үйл, хуримын ёслолын онолын үндсийг судлах.
2. Монгол хуримын зан үйлийн ялгаа, соёлын үнэ цэнийг тодорхойлох.
3. Хуримын аяллын зах зээлийн боломжийг шинжлэх.
4. Хуримын аяллын бүтээгдэхүүн боловсруулах загвар санал болгох.

Сэдвийн хамрах хүрээ

Энэхүү ажил нь Монголын уламжлалт хуримын ёслол, ялангуяа Төв халхын хуримын зан үйлийг жишээ болгон авч үзнэ. Судалгааны хүрээнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, соёлын аялал, зах зээлийн боломж, хөтөлбөрийн төлөвлөлтийн асуудлыг хамруулна.

Судалгааны ажлын таамаглал

Монголын уламжлалт хуримын зан үйл нь соёлын өвийн гүн утга агуулга, байгалийн өвөрмөц орчин, хэрэглэгчийн өндөр эрэлттэй нийлсэн тохиолдолд аялал жуулчлалын өрсөлдөхүйц бүтээгдэхүүн болон хөгжих боломжтой гэж таамаглав. Тодруулбал:

1. Дотоодын хэрэглэгчдийн 85-аас дээш хувь нь уламжлалт элемент агуулсан хурим хийхийг хүсдэг;
2. Олон улсын зах зээлд соёлын аяллын эрэлт жилд 10-аас дээш хувиар өсч байгаа нь Монгол хуримыг destination wedding бүтээгдэхүүн болгох боломжийг бий болгож байна;
3. Үндэсний уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгоход тулгардаг гол саад нь технологийн бус, харин мэдлэг мэдээллийн хомсдол болон мэргэшсэн зохион байгуулагчийн дутмаг байдал байна.

Сэдвийн судлагдсан байдал

Уламжлалт зан үйлийн талаарх судалгааг монгол угсаатны зүй, антропологи, соёл судлал, аялал жуулчлалын чиглэлээр олон эрдэмтэд авч үзсэн байдаг. Монгол хуримтай холбоотой судалгаанууд нь ихэвчлэн ёс заншлын бүрэлдэхүүн, угсаатны онцлог, гэр бүлийн харилцааны хүрээнд бичигдсэн боловч түүнийг аяллын бүтээгдэхүүн болгох талаас гүнзгий судалсан нь харьцангуй цөөн байна.

Энэ нь судалгааны шинэ талбар нээж буй бөгөөд уламжлалт зан үйлийг орчин үеийн аяллын багц болгон хувиргах онол, практикийн холболт шаардлагатайг харуулж байна.

Судалгааны арга зүй

Энэхүү эрдмийн ажилд дараах судалгааны арга, аргачлалыг хосолсон байдлаар хэрэглэв. Үүнд:

- Онолын шинжилгээ: Уламжлалт зан үйл, соёлын өв, аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн онолын үндсийг Монгол болон гадаадын эрдэмтдийн бүтээлд тулгуурлан судаллаа.
- Харьцуулсан судалгаа: Монгол угсаатны хуримын зан үйлийн ялгаа болон дэлхийн destination wedding зах зээлийн жишиг улс орнуудыг харьцуулан шинжлэв.
- SWOT шинжилгээ: Монгол хуримын аяллын бүтээгдэхүүний давуу тал, сул тал, боломж, аюулыг аялал жуулчлалын стратегийн хүрээнд нэгтгэн дүн шинжилгээ хийв.
- Ярилцлага: "Хөх отог" өв соёл хөгжлийн төвийн үүсгэн байгуулагч Ж.Лувсандорж, ардын судлаач С.Дамбий нартай зорилтот ярилцлага хийж, уламжлалт зан үйлийн утга агуулгыг нарийвчлав.
- Хэрэглэгчийн судалгаа (тоон арга): Google Forms платформоор санамсаргүй дэд бүлгийн буюу түүврийн (convenience sampling) аргаар Улаанбаатар хотын 18-аас дээш насны иргэдийн дунд нийт 109 хүнээс асуулгын судалгаа явуулав.

Судалгааны өгөгдлийг Microsoft Excel болон Google Sheets программаар статистик боловсруулалтад оруулж, хувийн харьцаа, тоон тархалтаар дүн шинжилгээ хийв. Судалгааны хамрах хүрээ нь голчлон Улаанбаатар хотын иргэдэд (79.8%) чиглэсэн тул үр дүн нь хотын хэрэглэгчийн хандлагыг илэрхийлнэ.

Шинжлэх ухаан, практикт оруулах хувь нэмэр

Энэхүү ажил нь уламжлалт ёслолын зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгох онолын үндсийг баяжуулж, Монгол хуримыг соёлын аяллын шинэ бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх практик загвар санал болгоно. Мөн соёлын өвийг хамгаалах, аялал жуулчлалын шинэ сегмент бий болгоход бодит хувь нэмэр оруулна.

I БҮЛЭГ. УЛАМЖЛАЛТ ЗАН ҮЙЛ, СОЁЛЫН ДАРХЛАА

1.1 Уламжлалт зан үйл, хуримын ёслолын ялгаа, мөн чанар

Уламжлал гэдэг нь “уламжлах үйлийн нэр; уламжлалыг дамжуулах явдал” гэсэн утгатай, мөн “үеэс үе дамжин удаан хугацаагаар хадгалан үлддэг нийгэм, соёлын өвийн зүйлс; залгамжлан авах зүйл” гэж толь бичигт тодорхойлсон байдаг. (mongoltoli.mn, 2016)

Зан үйл гэдэг нь хүний аж амьдралтай уялдан хэвшиж тогтсон заншил, түүнтэй холбоотой элдэв үйл хөдлөл хэмээн тайлбарласан байдаг. (Б.Энхболд, 2022) “Зан үйл нь тогтсон дэгтэй ёслолуудыг хүмүүс нийтээр биечлэн тоглон үйлдэх байдлаар зохион байгуулагдана. Энэ нь биет бус өвийн тээгч ба орчин нь хүний бие байдагтай холбоотой. Тухайлбал, гэрлэх зан үйлийн үеэр бэр буулгах, мэндлэх, бэлэг солилцох, бөгж зүүх, найр хийх зэрэг их олон ёслолыг тогтсон дэгээр тоглон үйлддэг.” ч гэж судлаачид томьёолсон байдаг. (Ж.Сампилдэндэв, 2006)

Уламжлал нь зан заншлаа багтаах бөгөөд зан заншил нь зан үйлүүдийг тээгч бөгөөд тэдгээрийн агуулгыг нь тодорхойлон хадгалж үеэс үед дамжуулан өвлүүлэхэд тусална. Зан үйл нь тогтсон ёслолууд болон баяр наадмуудаар дамжин үйлдэгддэг байна. (Ж.Сампилдэндэв, 2006)

Уламжлалт зан үйл гэдэг нь “Үеэс үед уламжлагдан ирсэн, нийгэм, соёлын туршлагаас шингэсэн, тодорхой давтагдаж байгаа үйлдлийн хэв маягийг хэлнэ.” (Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл, урлагийн газар, 2017) Энэ нь тухайн ард түмний амьдралын хэв маяг, соёл, итгэл үнэмшилд тулгуурлан үеэс үед дамжиж ирсэн ёс, дэг, үйл ажиллагааг хэлнэ.

Зураг 1.1 Монголын хүн амын өсөлтийн диаграмм



Эх сурвалж: (Ж.Сампилдэндэв, 2006)

“Монгол зан үйл, баяр, ёслолын товчоон” гэх гарын авлага номд уламжлалт зан үйлийг доорх байдлаар ангилан авч үзсэн байдаг. Тухайлбал:

- 1) Байгаль, цаг улирлын холбогдолтой зан үйл нь жилийн тодорхой нэг хугацаанд давтагдах байгаль, цаг уурын онцлог үзэгдэл түүнд зохицон улирлын чанартайгаар ээлжлэх ажил хөдөлмөрийн онцлогтой холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл олон зууны турш байгаль, уур амьсгалын өөрчлөлтийг ажиглан таньж мэдсэний үндсэн дээр тодорхой цаг тооны үечлэлийн дагуу давтагдах ажил хөдөлмөрийн үйл ажиллагаа буюу аж ахуйг хөтлөх түүхэн үүднээс бүрэлдэн тогтсон хэв ёсыг тусгадаг. (Ж.Сампилдэндэв, 2006)
- 2) Айл гэрийн зан үйл нь нийгмийн нэг гишүүний амьдралд тохиолдсон /хүүхэд төрөх, гэрлэх, насны ой тэмдэглэх, талийгаачийг оршуулах/ онцлог хүндэтгэлт үйл явдлыг ёслол тэмдэглэж түүнд хандах хамт олных нь ерөөн билэгдэх, хүндэтгэн ёслох, харуусан гашуудах зэрэг сэтгэлийн өнгө аясыг илэрхийлэхэд чиглэгдсэн уламжлалт зан заншил, аман яруу найргийн цогцолбор юм. Өөрөөр хэлбэл, хүний амьдралын эхнээс аваад эцсийг хүртэлх хугацаанд тохиолдох тэмдэглэлт явдлыг эртнээс уламжилсан заншил ёсны үүднээс ёслол тэмдэглэж буй хэрэг юм. (Ж.Сампилдэндэв, 2006)
- 3) Аж төрөх ёсны зан үйл нь монголчуудын нийгмийн болон амьдралын хэв маяг болох нүүдэллэх ёсон, байгаль орчинтойгоо зохицон амьдрах ухаан, ан ав хийхтэй холбоотой хорио цээр, мал болон тариалан эрхлэхтэй холбоотой хүндлэл, бэлгэдэл дээр суурилсан баялаг уламжлал юм. (Ж.Сампилдэндэв, 2006)
- 4) Шашны зан үйл нь хөх тэнгэр хөрст дэлхийг эрхэмлэн тахин шүтсээр ирсэн уламжлалт зан үйлүүд багтах бөгөөд овоо тахих, гал голомтоо эрхэмлэн дээдлэхтэй холбоотой хорио цээрийн ёс, монголчуудын эртний шашин суртахуун болох бөө мөргөлийн зан үйл, цамын ёслол зэрэг нүүдэлчин ахуйн онцлогтой хосолсон өвөрмөц уламжлалын хэлбэр юм. (Ж.Сампилдэндэв, 2006)

1.1.1 Хуримын ёсон

Хүний хувь заяанд төрсний учир гэрлэх ёслол үйлдэн өрх өсгөж, сум сунгах нь хүний амьдралд тохиолдох эрхэм ёс бөгөөд хүний амьдралын туйлын эрхэм сайхан баяр болно. Монгол хэлний хурим гэдэг үг нь олон утгатай бөгөөд номын хурим, гэрлэх, дайллагын хурим, баярын хурим, насны найр өргөн дэлгэр утгатай. (Г.Нандинбилиг, 2020)

Гэрлэх ёс төр үйлдэхийг хурим гэж нэрлэдэг. (Хорлоо, 1999)

Гэрлэх ёс заншил олон янз байдаг. Босгож авах, богтолж авах ба татварлаж авах, хүргэн орох ба гуйж авах, андалдаж авах, эргэлдүүлж авах ба суйвдаж авах зэрэг урьд цагийн түүхэнд олон янз байсныг түүх, шастир, үлгэр тууль зэрэг утга зохиолд тэмдэглэн үлджээ. (Сүхбат, 2013)

Монголчууд цөөн хүн амтай жижиг үндэстэн боловч дотроо олон овогтон, ястантай тэдний өвөрмөц зан үйлийг тусгасан гэрлэх ёс төрөөр өргөн баялаг билээ. Эдгээр нь тус тусдаа өвөрмөц шинжтэй.

Монгол улсад өнөөдөр хүн амын 94 орчим хувь нь гарал үүслээр нэг, ойр төрөл угсаатнуудаас бүрдэх монгол үндэстэн, 5 хувь нь казах үндэстэн байна. Монгол үндэстний 17-18 хувийг буриад, дөрвөд, баяд, урианхай, захчин, торгууд, өөлд, мянгад, дархад, барга, үзэмчин, хамниган, чантуу эзэлдэг. Монгол угсаатан бүхэнд хуримлах заншил байдаг. (Сүхбат, 2013)

Аливаа үндэстэн, ястан, бүлгийн аман болон биет бус өв бол уг өв оршиж байгаа газар нутаг, орон зай, тухайн бүлгийн эрхэлдэг аж ахуй, аж төрөх ёс, хэл, соёл, иргэншлийн түүхэн нөхцөл байдлаас үүдэн өөр өөрийн давтагдашгүй ялгарах онцлогтой байна.

Монгол улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлагын ангилалд дараах хуримын ёс, зан үйл багтсан байна. (Б.Буяннэмэх, 2025)

Хүснэгт 1.1 Монгол ястны хурим

Монгол угсаатан		Өвөрмонгол
1. Баяд хурим	2. Тува хурим	1. Барга хурим
3. Боржигин хурим	4. Урианхай хурим	2. Хорчин хурим
5. Буриад хурим	6. Халх хурим	3. Цахар хурим
7. Дархад хурим	8. Хамниган хурим	4. Баарин хурим
9. Дарьганга хурим	10. Хотгойд хурим	5. Аваганар хурим
11. Дөрвөд хурим	12. Хотон хурим	6. Сөнид хурим
13. Захчин хурим	14. Хошууд хурим	7. Урад хурим
15. Казак хурим	16. Цаатан хурим	8. Алшаа хурим
17. Мянгад хурим	18. Торгууд хурим	9. Шинжиянд хурим
19. Өөлд хурим	20. Үзэмчин хурим	10. Дээд монгол хурим

Эх сурвалж: (Боловсрол, 2019), (Ж.Самтилдэндэв, 2006)

Халхчууд гэрлэх хуримыг гэр бүлийн холбооны баталгаа гэж үздэг өвийн уламжлалтай. Тийм болохоор харилцан эхнэр нөхөр бологсад гэрлэх хуримаа “Заяаны

хурим” гэж нөхөр нь гэрийнхээ чагтгыг уяж, эхнэр нь галаа асааж нэг бүлийн шинэ “гал голомт” буй болдог.

Үүнийг 1709 онд “Халх журам (1709)” хуулиар баталгаажуулж олонд тунхагладаг байсан ба халх монголын гэрлэх ёс бол хатуу хуультай байсан ба нэгэнт хуримласан нөхөр эхнэр хоёрын салах сарних явдал санааны зоригоор биш, хуулийн заалтаар шийдвэрлэдэг байв.

Хүснэгт 1.2 *Халх ястны хуримын зан үйлийн ялгаа*

Халх	Хуримлах ёс
Төв халхын хуримлах ёс	<ol style="list-style-type: none"> 1. Ам турших 2. Сүй тавих 3. Тахил тавих 4. Тэвш тавих 5. Бэр мөргүүлэх 6. Эргэлтийн найр 7. Мөр бүтээх
Дорнод халхын хуримлах ёс	<ol style="list-style-type: none"> 1. Тахилын үг 2. Сумны ерөөл 3. Гэр мялаалгын үг 4. Хөөгүүлийн үг 5. Эхийн цагаан сүүний харамжийн үг 6. Үүдэн дарлагын үг 8. Хаяа тэлэх үг
Өмнөд халхын хуримлах ёс	<ol style="list-style-type: none"> 1. Бэр гуйх 2. Охин авах 3. Ерөөлүүд 4. Гэрийн мялаалгын үг 5. Бүртгэлийн ерөөл 6. Хуримын ерөөл 9. Сүй морины ерөөл

Эх сурвалж: (Хорлоо, 1999)

1.1.2 Хуримлах ёсын ялгаа

Хүснэгт 1.3 *Монгол угсаатны хуримын зан үйлийн харьцуулалт*

	Халх	Дарьганга	Дөрвөд	Баяд	Буриад	Захчин
Бэр гуйх ёс	Ам турших Аман хадаг тавих	Хадаг тавих	Ам алдуулах Хадаг тавих Худ хэлэх Худ хүргэж Зул дээж өргөх	Ам дуулгах Аман хадаг тавих	Бэр эрэх хадаг Хадаг барих Морь унуулах	Ам сонсгох Хэл хүргэх Хадаг бараалхуулах Баталгаа хийх Хуйх барих

Сүй тавих	Сүй тавих Тахилга тавих		Зус хадаг хүргэх	Зус хадаг өгөх	Мал бариулах	Идээний дээж хүргэх Зус барих Хүргэн айлчлах
Хуримын бэлтгэл	Шинэ гэр барих		Гэр бүрэх Эд хүргэх	Гэр бүрэх	Шинэ гэр барих	Гэр бүрэх Эд сэв эсгэж өгөх
			Эд оёх (ор дэр оёх)	Ор оёх		Дэр дэвсгэр эсгэх
Хуримын өмнөх зан үйл	Цай уух		Гийч цайлуулах	Цагаа уух	Басган зайх	Халхаар цайлуулах
			Гичиг буулгах	Гэээг татлах	Басганы наадам хийх	Гэээг буулгах
	Тэвш тавих		Тэвш өргөх	Гийч буулгах		
Хуримын агаа тэмцэл	Үүдэн дарлага Өвчүү цахих Таваг цохих Бунд уралдуула х	Үүдэн дарлага Арьс татах Таваг цохих	Үүдэн даллага Малиа тавих Арьс татах Таваг цохих Төөлэй булаалдах Чөмөг хөөх	Арьс татах Өвчүү цахих Таваг цоихи Төөлэй булаалдах Хүргэн халтиргах Чөмөг хөөх Алчуур татах	Чимэг хөөх Нар булаалдах	Үүдэн даллага Арьс татах Малгай уралдуулах
Хуримын ёслол	Хүүхэн мордуулах	Бэр буулгах	Охин мордуулах	Өмсгөл өмсгөх Бэр булаалдах	Бэр буулгах	Охин мордуулах Бэр буулгах
	Бэр мөргүүлэх		Бэр мөргүүлэх Нохой сэтэрлэх Шанага сэтэрлэх Бэрд мал зүслүүлэх	Бэр мөргүүлэх		Бэр мөргүүлэх
	Бэрийн үс хагалах			Сэв нийлүүлэх		

	Хурим					Шинэ гэрийн хурим
Дараах Үе	Эргэлтийн найр Мөр бүтээх Булангийн найр	Гурав хоногийн эргэлт	Гийч буцах хурим Хөшиг тайлах	Бэргэдийн найр Хөшиг тайлах	Хуримын хөөлгө	Бэлэг өгөх Хөшиг тайлах
	Бэр төрхөмчлөх					

Эх сурвалж: (Г.Нандинбилиг, 2020)

Нэгдүгээрт: Овогтон бүрийн гэрлэх ёс нь уламжлалын хувьд ялгаатай. Тухайлбал: Ордос ба Дээд Монголын гэрлэх ба зан үйл нь эртний уламжлалыг нэлээд баттай үлдээн хадгалж өнөөгийн хуримлах зан үйлийг төгөлдөржүүлж байна.

Ялангуяа Ордос хуримын ёслолд “Саадаг мордох ёслол”, “Нэр жил гуйх ёслол” гэрлэлтийг эх болж “Хонжин дэвтэр”-т дурдсан дэгээр олон ёслол байгаа бол Дээд монголын гэрлэлт нь бөөгийн мөргөлийн тайх тахиx мөргөлийн зан үйлийг гол болгож гэрлэгсэд хувь заяагаа “Тэнгэрт даатгаж” аврал гуйх “Шагай чөмөг атгаж шар наранд мөргөх” зан үйл нэлээд байдаг ажээ.

Хоёрдугаарт: Монголчуудын хуримлах ёс ард олны төр ёсны нэг том ёслол. Энэ нь янз янзын хэлбэр агуулгаар явагддаг. Халхад хуримлах ёсны гэрлэлт нь “Бэр мөргүүлэх” их хуримаар төгөлдөрждөг бол Дөрвөд хуримд “Тэр бүрэх найр”, “Эд өгөх найр”, “Хөшиг тайлах найр” гэж олон найр хийдэг нь их хуримыг төлөөлдөг юм.

Гуравдугаарт: Монголчуудын хуримлах зан үйлийг ардын найргаар илэрхийлэх нь нийтлэг шинж боловч тэр бүр адилгүй яруу найраг ардын урлагийн өөр өөр төрлийг голлон хэрэглэдэг ялгаатай юм. Тухайлбал халхчуудын хуримлах ёсонд ерөөлийн ба уртын дууны төрөл зүйл голлодог бол Буриадын хуримд дуу дуулж бүжиг бүжих, наадамд тоглоом хийх, Ордос хуримд ардын жүжгийн харилцаа, шүлэг хэлэлцэх, цэц булаацалдах, ухаан сорих мөчлөг шүлэг тавилцах, Дээд монголын хуримд зүйр цэцэн үгс, Бэлэг дэмбэрлийн үгс хэлэлцэх, сан тахилын ерөөл тавилцах, Дөрвөдийн хуриманд харилцаа шүлэг, захиас холбоо үг зэргийг голлон зориулахаас гадна дуу дуулахдаа "морин"-ы тухай дуу голлон дуулдаг юм. Энэчлэн ерөөл тавих дуулахдаа овогтон бүр өөр өөр хөгжмийн зэмсэг хэрэглэдэг.

Халхчууд морин хуур хуурдаж найрын 32 аялга дуу дуулдаг бол Дөрвөдүүд "эхэл" хөгжим, Ордос "хуучир" хөгжмийг голлон гэрлэх хуримдаа дуу хуур болгодог эртний заншилтай.

Дөрөвдүгээрт: Монголчуудын гэрлэх ёсонд сүй бэлэг барилцах нь бас өвөрмөц. Халх, Буриад нар сүй бэлэг барихдаа хурдан морь, төллөх мал барьдаг ёстой бол Ордосчууд бэрийн нэр жилийг тогтоон хүү нь хүүхэндээ алтан мөнгөн гархи барьдаг ажээ. Энэ нь Ордосын гэрлэлтийн сүйн нэг хэлбэр. Буриадууд энэ ёсыг уламжлан гэрлэлтийн ёслолын үеэр "бөлзөг" нууж тоглодог ёс дэлгэрчээ. (Сүхбат, 2013)

Хуримын ёслолын ялгаа, мөн чанарыг дүгнэхэд, уламжлалт зан үйл ялангуяа хуримын ёслол нь олон давхаргат утга учир, бэлгэдэл, нийгмийн харилцааны цогцолборыг агуулсан биет бус соёлын өв болохоос гадна аяллын бүтээгдэхүүний хувьд дэлхийн аль ч хуримаас ялгарах өвөрмөц агуулга, олон янзын хэлбэрийн нөөцтэй болохыг тогтоолоо.

1.2 Хуримын аялал жуулчлалын зах зээлийн боломж

Дэлхийн аялал жуулчлалын салбар нь жилд 9.9 их наяд ам.долларын эдийн засгийн эргэлттэй, дэлхийн ДНБ-ний 10 орчим хувийг бүрдүүлдэг асар том салбар юм (UNWTO, 2024). Энэхүү том зах зээлийн дотор хуримын аялал жуулчлал нь хамгийн хурдтай өсөж буй сегментүүдийн нэг болж өнөөдрийг хүрчээ.

Destination wedding буюу хуримын аялал жуулчлалын зах зээл нь 2024 онд 32.8-39.2 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд нийт дэлхийн аялал жуулчлалын орлогын 0.3-0.4 орчим хувийг бүрдүүлж байна. Энэ тоо харьцангуй бага мэт санагдавч хуримын аялал нь нэг аялагчид ногдох зарцуулалт хамгийн өндөр сегментүүдийн нэг юм. Жишээ нь, ердийн жуулчин Монголд дунджаар 889 ам.доллар зарцуулдаг бол хуримын аяллаар ирсэн хос 3,000-15,000 ам.доллар зарцуулдаг.

Хүснэгт 1.4 Дэлхийн хуримын аялал жуулчлалын ерөнхий үзүүлэлт

Үзүүлэлт	Тоо хэмжээ	Эх сурвалж
Дэлхийн аялал жуулчлалын нийт орлого (2024)	\$9.9 их наяд	UNWTO, 2024
Нийт хурим, гэрлэлтийн зах зээл (2024)	\$253.5 тэрбум	Business Research Insights, 2024
Destination wedding зах зээл (2024)	\$32.8-39.2 тэрбум	IMARC Group / DataIntel, 2024
Destination wedding-ийн өсөлтийн хурд (CAGR)	12.7-17.3% (2025–2033)	DataIntel / IMARC, 2024
Destination wedding зах зээл (2033 таамаглал)	\$96.4-171.1 тэрбум	DataIntel / IMARC, 2024
Нийт хуримын destination хэлбэрт шилжсэн хувь	15–20%	VARNIYA Research, 2025

Эх сурвалж: (DataIntel, 2024), (Group, Global Destination Wedding Market, 2024) (VARNIYA, 2025)

Хуримын аялал жуулчлалын бүс нутгийн хуваарилалтыг авч үзвэл Ази-Номхон Далайн бүс тэргүүлж байна. DataIntel (2024)-ийн судалгаагаар Ази-Номхон Далайн бүс дэлхийн destination wedding зах зээлийн 38%-ийг буюу 12.5 тэрбум ам.долларын эзлэхүүнтэй байгаа нь гайхалтай үр дүн юм. (Research, 2024)

Энэхүү давамгайллыг Тайланд, Бали, Энэтхэг, Мальдивын үзэсгэлэнт байршил, харьцангуй хямд үнэ, дунд зэрэглэлийн хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгаатай холбон тайлбарладаг.

Хүснэгт 1.5 Дэлхийн хуримын аялал жуулчлалын ерөнхий үзүүлэлт

Бүс нутаг	Зах зээлийн хувь (2024)	Хэмжээ (тэрбум \$)	CAGR таамаглал
Ази-Номхон Далай (APAC)	38%	\$12.5	14.3% (хүртэл 2033)
Хойд Америк	27%	\$8.9	Умартаж буй
Европ	22%	\$7.2	19% (Европын дэд зах)
Латин Америк, Дорнод Афри	13%	\$4.2	Хурдтай өсч буй

Эх сурвалж: (DataIntel, 2024) (UNWTO, 2024)

Хойд Америк нь Data Bridge Market Research (2024)-ийн судалгаагаар нийт зах зээлийн 40% гаруйг эзэлж байгаа нь Мексик, Карибын тэнгис, Хавай зэрэг алдартай байршлуудтай холбоотой.

Харин Ази-Номхон Далайн бүс нь 2033 он хүртэл 14.3%-ийн жилийн дундаж өсөлтийн хурдтайгаар хамгийн хурдтай өсөж буй бүс болох тооцоо гарч байна. Монгол улс Ази-Номхон Далайн бүсэд байрлах тул энэ хандлагыг хамгийн шууд ашиглах боломжтой.

Хүснэгт 1.6 Монгол Улс дахь хуримын аялал жуулчлалын боломжийн тойм

Боломжийн хэмжүүр	Агуулга	Дүгнэлт
Байгалийн тогтоц	Говь, Хөвсгөл, Алтай, тал хээр	Дэлхийд цорын ганц
Уламжлалт зан үйл	Монгол хуримын 4 үе шат	100 жилийн түүхтэй
Өрсөлдөгч байдал	Destination wedding ойрын өрсөлдөгч байхгүй	Анхдагч зах зээл
Зорилтот хос	Жил бүр 727,000 жуулчин	1-2%, 7,000-15,000 хос
Гадаадын зах зээл	Солонгос, Япон, Баруун Европ	Соёлын хурим эрхэмлэдэг
Засгийн газрын дэмжлэг	"Монголд зочлох жил" 2023-2028	Стратегийн нийцтэй

Дэлхийн хуримын аялал жуулчлалын зах зээл (destination wedding market) хурдацтай өсөж байна. Олон улсын судалгааны байгууллагуудын тоо баримтаар 2024 онд дэлхийн destination wedding зах зээлийн хэмжээ 39.2 тэрбум ам.доллар болсон бол

2033 он гэхэд 171.1 тэрбум ам.долларт хүрэх буюу жилд дунджаар 17.3%-иар өсөх таамаглалтай байна (IMARC Group, 2024).

Азийн Номхон далайн бүс энэхүү өсөлтийг тэргүүлж байгаа бөгөөд 2024 онд дэлхийн хуримын үйлчилгээний зах зээлийн бараг гуравны хоёрыг эзэлсэн байна. Дэлхийн хэмжээнд зохион байгуулагдсан нийт хуримын 26% нь destination wedding байсан нь хоёр жилийн өмнөхөөс (18%) мэдэгдэхүйц өссөн байна (Grand View Research, 2025).

Хүснэгт 1.7 *Аяллын бүтээгдэхүүний хувьд Монгол хуримын давуу болон сул тал*

Давуу тал	Сул тал
Дэлхийд цорын ганц, өвөрмөц зан үйл	Тогтмол бус хуваарь, улирлын хязгаарлалт
Байгалийн гайхамшигт дэвсгэртэй хослуулах боломж	Хэлний бэрхшээл, орчуулагч тайлбарлагчийн хомсдол
Монголын нэмэлт соёлын туршлагатай давхцах нь	Дэд бүтцийн дутагдал (хол газрын хувьд)
Уламжлалт хувцас, хоол, дуу хуурын уламжлалт байдал	Хуримын гэр бүлийн хувийн ёслолтой нийцэх нь
Хямд зардалтай эко-туризмтай нийцтэй	Стандартчилагдаагүй хуримын бүтээгдэхүүн
Go Mongolia брэндийн дэмжлэг авах боломж	Мэдэгдэл, сурталчилгааны дутагдал

Хуримын аялал жуулчлалын зах зээлийн боломжийн хувьд, дэлхийн хуримын аялал жуулчлалын зах зээлийн хурдтай өсөлт болон Ази-Номхон Далайн бүсийн тэргүүлэх байр суурийг харгалзан үзвэл Монгол Улс хуримын аяллын тодорхой зах зээлийг эзлэх бодит боломжтой хэдий ч тэрхүү боломжийг хэрэгжүүлэхэд системтэй хөгжүүлэлт, стандартчилал шаардлагатай болохыг энэхүү дүн шинжилгээ харуулж байна.

1.3 Хуримын аяллын хөтөлбөрийн шинжилгээ

1.3.1 Өрсөлдөгчийн шинжилгээ

Монгол хуримыг аяллын бүтээгдэхүүн болгоход шууд өрсөлдөгч одоогоор дотоодод хязгаарлагдмал байгаа нь "анхдагч зах зээлийн" давуу байдлыг бий болгож байна.

Хүснэгт 1.8 *Өрсөлдөгч байгууллагуудын мэдээлэл*

№	Нэр	Ангилал	Хуримын үйлчилгээ	Эх сурвалж
1.	Гэрлэх ёслолын ордон	Төрийн байгууллага	1976 онд байгуулагдсан, 40 жилийн туршлагатай,	(Гэрлэх ёслолын ордон, 2026)

№	Нэр	Ангилал	Хуримын үйлчилгээ	Эх сурвалж	
	(ОНӨААТҮГ)		36,800 гаруй хос гэрлүүлсэн. Уламжлалт монгол хурим, "Төрт ёсны" дэглэмийн дагуу ёслол үйлддэг.		
2.	Брэнд медиа цогц үйлчилгээ	Хувийн компани-Хурим зохион байгуулалт	2014 онд соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр үүсгэн байгуулагдсан дөрвөн улирлын турш тасралтгүйгээр тоглолт, видео контент болон хуримын цогц үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлдэг анхдагч байгууллага.	(Brand Media Group, 2021)	
3.	Монголиан эвэнт веддинг сервис компани		Хурим, ёслол болон арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн үйлчилгээний компани юм.	(Mongolian Event Wedding Service Company, 2026)	
4.	Энтертайнмент.мн		2012 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй энтертайнмент бүхий л төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжлийн байгууллага.	(Entertainment.mn, 2026)	
5.	Найр.мн		Үндэсний урлагийн тоглолтын үйлчилгээ үзүүлэхийн сацуу Монгол найрын соёлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэгч компани юм.	(Найр энтертайнмент, 2026)	
6.	Содон хурим		Монгол үндэсний уламжлал, соёлын онцлогийг шингээсэн хурим, ёслолын арга хэмжээг мэргэжлийн түвшинд зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.	(Содон хурим, 2026)	
7.	Мондакт ХХК- Их Монгол Өргөө (Glory Resort)		Уламжлалт гэр	32 метр диаметртэй, Монголын хамгийн том гэр эвэнт танхим. 300-800 зочин хүлээн авах	(monduct.mn, 2025)

№	Нэр	Ангилал	Хуримын үйлчилгээ	Эх сурвалж
			хүчин чадалтай. Монгол байгалийн орчинд уламжлалт гэр танхимтай хурим зохион байгуулдаг.	
8.	Монгол Шилтгээн		Чингисийн өргөө гэр ресторан, үндэсний эсгий гэрүүд, бэсрэг наадмын талбайтай. Хурим найрын арга хэмжээ зохион байгуулна. 250–500 зочин.	(huree.mn, 2025)
9.	Шангри-Ла зочид буудал	5 одтой зочид буудал	"Marry Me" хуримын багцууд, 4 ресторан, уламжлалт болон орчин үеийн хурим	(shangri-la.com, 2026)
10.	Скай Ресорт- Богд хан уулын хурим	Ресорт	Автомат дүүжин замаар уулын оройд хүрч бөгжөө солилцох, Туулын урсгал, нийслэл хотыг харагдуулан хуримын ёслол хийдэг. Шинэ орчин үеийн загвартай.	(skyresort.mn, 2025)

✓ Байдаг

▲ Хэсэгчилсэн

✗ Байдаггүй

Хүснэгт 1.9 Бүх ангиллыг нэгтгэсэн цогц харьцуулалт

Байгууллага	Уламжлалт хурим	Бөгж солилцох ёс	Буйраа засах ёс	Ачлал өргөх ёс	Бэрийн цай чанах	Сүүний ёслол	Гал тахиx ёс	Сав бүтээх ёс	Ууц хөндөх ёс	Сөн дүүргэх ёс	Ерөөл магтаал	Уртын дуу	Үндэсний хөгжим	Үндэсний бүжиг
Гэрлэх ёслолын ордон	✓	✓	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗	✓	▲	▲	✗
Брэнд медиа цогц үйлчилгээ	▲	✓	✗	✗	✗	✓	✗	✗	✓	✓	✓	✓	✓	✓
Монголиан эвэнт веддинг сервис компани	▲	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✓	✗	✗	▲	✗	✗
Энтертайнмент.мн	▲	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✓	✗	✓	✗	✗	✗

Байгууллага	Уламжлалт хурим	Бөгж солилцох ёс	Буйраа засах ёс	Ачлал өргөх ёс	Бэрийн цай чанах	Сүүний ёслол	Гал тахиx ёс	Сав бүтээх ёс	Ууц хөндөх ёс	Сөн дүүргэх ёс	Ерөөл магтаал	Ургын дуу	Үндэсний хөгжим	Үндэсний бүжиг
Найр.мн	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✓	✓	✓
Содон хурим	▲	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✓	✓	✓	▲	▲	▲
Мондакт ХХК- Их Монгол Өргөө	✓	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✓	✗	▲	▲	▲	▲
Монгол Шилтгээн	✓	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✓	✗	▲	▲	▲	▲
Шангри-Ла зочид буудал	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✓	✗	✗	▲	▲	▲
Скай Ресорт- Богд хан уулын хурим	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✓	✗	✗	✓	✓	▲

Хүснэгтийн харьцуулсан судалгаанаас үзэхэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хурим, эвент болон ёслолын үйлчилгээний байгууллагуудын дийлэнх нь орчин үеийн хуримын зохион байгуулалт, тайз чимэглэл, ерөнхий үйлчилгээний чиглэлд төвлөрөн ажиллаж байгаа нь ажиглагдаж байна. Харин монгол үндэсний уламжлалт хуримын зан үйл, ёс дэг, бэлгэдэл, ахуйн соёлыг иж бүрнээр нь агуулсан үйлчилгээ харьцангуй хязгаарлагдмал түвшинд хэрэгжиж байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас “Гэрлэх ёслолын ордон” нь уламжлалт хуримын зарим зан үйлийг тусгасан боловч үндэсний өв соёлыг бүрэн цогцоор нь хэрэгжүүлдэггүй байна. “Брэнд медиа групп”, “Монголиан эвент веддинг сервис компани”, “Энтертайнмент.mn”, “Содон хурим” зэрэг байгууллагууд нь голчлон эвент, зохион байгуулалт, медиа үйлчилгээний чиглэлд төвлөрсөн бөгөөд уламжлалт зан үйлийн агуулга харьцангуй бага байгааг хүснэгтээс харж болно.

Мөн зочид буудал, хуримын танхимын үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагууд нь хуримын орчин, үйлчилгээний нөхцөлөөр давуу талтай боловч үндэсний уламжлалт зан үйлийг иж бүрэн хэлбэрээр хэрэгжүүлэх боломж харьцангуй сул байна.

Иймээс энэхүү өрсөлдөгчдийн хөтөлбөрийн харьцуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд Монголын уламжлалт хуримын зан үйлийг орчин үеийн үйлчилгээ, аялал жуулчлал, эвент зохион байгуулалттай хослуулсан, соёлын өвийг хадгалан түгээн дэлгэрүүлэх чиглэл бүхий цогц үйлчилгээний зах зээлийн хэрэгцээ, боломж өндөр байна гэж дүгнэж болно.

II БҮЛЭГ. ХУРИМЫН АЯЛЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖ

2.1 Хуримын аяллын зах зээлийн судалгаа


2.1.1 Хүн ам зүйн орчин-Дотоодын жуулчин

2026 оны байдлаар Монгол Улсын хүн амын тоо **3,556,798** (ойролцоогоор 3.56 сая) байна.

Хүйсийн харьцаа:

- Эрэгтэй: 1,771,340 (49.8%)
- Эмэгтэй: 1,785,475 (50.2%) буюу 1000 эмэгтэйд 975 эрэгтэй байгаа бөгөөд энэ нь дэлхийн дунджаас бага үзүүлэлт юм.

Зураг 2.1 Гэрлэлтээ бүртгүүлсэн хосуудын тоо /жилээр/



Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2025)

Гэрлэсэн хосуудын хувьд 18-аас дээш насныхны 61.1% гэрлэсэн. Сүүлийн жилүүдэд гэрлэлтийн нас хойшилж, хувь буурч байгаа ч тодорхой шинэ статистик хомс байна.

Монголд нийт хүн амын **49.9%** нь гэрлэсэн байдаг бол гэрлэж байгаагүй хүмүүс 34.6% эзэлдэг. Насны ангиллаар нь авч үзвэл 25–34 насны залуучуудад эмэгтэйчүүдийн

55.5% гэрлэсэн байхад эрэгтэйчүүдийн 43.7% гэрлэсэн байна. 45–55-аас дээш насанд хүйс хоёулаа бараг **95.8%** гэрлэсэн байдаг. (Inside Mongolia, 2025)

Зураг 2.2 Гэрлэлтээ батлуулсан хосуудын тоо /жилээр/



Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2025)

Нийт ойролцоо (2015–2024) оны байдлаар 171,000–175,000 хос бий болж байна гэсэн үг юм. Монгол эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 2010 онд 24.2 байсан бол 2018–2020 онд 26 болж өссөн байна. (Номин, 2021)


Манай улсад хууль ёсны гэрлэлт жил ирэх бүр нэмэгдэж байна. Үндэсний статистикийн газраас 2016 онд 16,800 гэр бүл гэрлэлтээ батлуулж байсан бол 2018 онд 21,020 гэр бүл гэрлэлтээ батлуулсан гэсэн судалгаа гаргасан. Гэвч албан ёсны гэрлэлт нэмэгдэхийн хэрээр гэр бүл цуцлалт ч нэмэгдэж байна.

Монгол Улсад жилд дунджаар ойролцоогоор 20 мянга орчим гэр бүл гэрлэлтээ батлуулдаг бөгөөд түүнчлэн жилд 3,800–4,500 орчим гэр бүл гэрлэлтээ цуцлуулдаг гэсэн судалгаа мэдээлэл байна. Гэхдээ энэ тоо бол зөвхөн хууль ёсны бүртгэлтэй гэр бүлийн салалт юм.

Зураг 2.3 Гэрлэлт ба цуцлалтын харьцуулалт

ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТЫН ТОО, аймаг, нийслэл, жилээр

Эх сурвалж: www.nso.mn, www.1212.mn



Highcharts.com


Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2025)

2024 оны байдлаар 14,225 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4,463 хос гэрлэлтээ цуцлуулсан байна. 2002 онтой харьцуулахад 2024 онд 31.3% болж цуцлалтын хувь 6 дахин өссөн байна. Өдөрт дунджаар 10–12 гэр бүл салж байгаа нь нийгмийн хурцадмал асуудал болоод байна (ҮСХ, 2024; The Diplomat, 2025).

2019 онтой харьцуулахад 2024 онд гэрлэлтийн тоо 29 хувиар буурсан боловч гэр бүл цуцлалтын тоо 5 хувиар өссөн үзүүлэлт гарсан гэж “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгаанд дурдсан байдаг. Энэ нь гэрлэлтийн хүчин зүйл буурч, харин харилцааны тогтвортой байдал доройтсон хандлагыг илт үзүүлж байна. (Гэр бүл, 2025)


Монгол Улсын хүн амын динамик нь хуримын аяллын бүтээгдэхүүний зах зээлийн эрэлтийг шууд тодорхойлно. 2024 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3.5 сая давсан бөгөөд нийт хүн амын 70 орчим хувь нь Улаанбаатар хотод амьдарна. Энэ нь бүтээгдэхүүний маркетингийг нийслэлд чиглүүлэх боломж юм.

Зураг 2.4 Гэрлэлт ба цуцлалтын тоо /жилээр/



Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2025)

Зураг 2.5 Гэрлэлтэд эзлэх цуцлалтын хувь



Гэрлэлтэд эзлэх цуцлалтын хувь (2010-2024)

Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2025)

Гэрлэлтийн статистик шууд эрэлтийн суурийг тодорхойлно. Монгол Улсад жилд дунджаар 25,000-30,000 гэрлэлт бүртгэгддэг (ҮСХ, 2025). Нийт гэрлэгсдийн 18-28% нь уламжлалт элемент агуулсан хурим хийхийг хүсдэг гэж судалгааны үр дүнгээс тооцвол жил бүр 4,500-8,000 хосын шууд зах зээлийн эрэлт бий.

Хүн ам зүйн орчны дүгнэлт

Дотоодын хүн ам зүйн орчны шинжилгээ нь хуримын аяллын бүтээгдэхүүний тодорхой, хэмжигдэхүйц дотоодын зах зээл бий болж байгааг баталж байна. Нэмж дурдвал, гэрлэлтийн дундаж нас хойшилж, уламжлалт соёлд хандах залуу үеийн сонирхол нэмэгдэж байгаа нь дотоодын эрэлт ирэх жилүүдэд тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.1.2 Нийгэм соёлын орчин

Орчин үеийн хосуудын хуримд Барууны соёл (цагаан даашинз, бялуу зүсэх, оргилуун дарс) давамгайлж байгаа нь буруу биш ч, хуримын утга учир нь зөвхөн үзэмж төдий болоод байгаа нь асуудал юм.

Залуу хосуудын 70-80% нь хуримын арга хэмжээгээ Европын загвараар хийж байна. Энэ нь зөвхөн "Show" буюу үзүүлбэр тал руугаа хэлбийж, гэр бүл болохын хариуцлага, ахан дүүсийн холбоо, ураг төрлийн барилдлагын гүн утгыг орхигдуулж байна.

Хотжилт нэмэгдэж, залуу үе уламжлалаасаа холдож буй нэгэн талаасаа уламжлалт хуримыг аяллын бүтээгдэхүүн болгоход хотын иргэдийн хүсэл сонирхлыг ашиглах боломж нээгдэж байна.

Төв халхын хуримын зан үйлд "Сүй тавих", "Бэр мөргүүлэх", "Тэвш тавих" зэрэг зан үйлүүд нь зөвхөн ёслол биш, хоёр талын ураг төрлийг гагнаж, хосуудад "Бие даасан тусдаа гэр бүл боллоо" гэх сэтгэл зүйн бат бөх босгыг үүсгэдэг байв.

Хосуудын харилцааны муу шинж тэмдгийг тайлбарлагч эрдэмтэн, соёл судлаачдын дүгнэлтүүдийг түүвэл:

Соёл судлаач Ж. Долгорсүрэн “Өнөөгийн дийлэнх гэр бүл Монгол уламжлал ч үгүй, орчин үеийг л захирахад орсон байна” гэсэн судлаачийн үгээр, хурим хийх, бэр гуйх, өвөг дээдсийн хандаж, хариуцлагыг нэмэгдүүлэх ёслолыг орхигдуулах тусам гэр бүлийн харилцааны тогтвортой байдал буурч байна гэсэн эрдэмтний дүгнэлт байдаг.

Гэр бүлийн соёлын цогцолборын хувьд хуримын ач холбогдол:

Хуримыг “хосууд биесийгээ насан турш хайрлана гэсэн итгэл сэтгэлийг нийтийн өмнө баталгаажуулдаг, түүн дээр нь үндэсний хариуцлагыг нэмэгдүүлдэг төр ёсны үйл” гэж тодорхойлсон байдаг. Энэ нь Хэрэв хосууд уламжлалт хуримын бүх үе шатыг (бэр гуйх, бэр охин авах, хурим найр, хариуцлагын үгс) бүрэн дуусгалгүй хийх, эсвэл

ихэвчлэн “барууны загвар” хуримын элементээр хангамжийг хязгаарлаж байвал, хосууд хариуцлагын түвшин сул байх, иймд гэр бүлийн салалт нэмэгдэх магадлал ихсэх юм.

И.Кант гэрлэлтийг “өөр хүйсийн хоёр хүн бие биеийн хүйсийн шинжийг насан турш эзэмдэхийн тулд нэгдэх явдал” буюу “хууль ёсоор харилцах хүйсийн харилцаа” өөрөөр хэлбэл “хууль ёсны гэрээ” гэж тодорхойлж байжээ. (Намжил, 2014)

О.Кант гэр бүл нь дээд үеэсээ уламжлалаа өвлөн авах үүрэг хүлээж байдгийн хувьд нийгмийн дэвшлийн эх сурвалжийг өөртөө агуулж байдаг гэж үзсэн нь ач холбогдолтой. Гэр бүлийн хамгийн гол үүргийн нэгэн бол үе үеийн залгамж уламжлалыг хангасаар байх явдал юм. (Намжил, 2014)

Гэрлэлтийг тодорхойлохдоо насанд хүрсэн эрэгтэй эмэгтэй хоёр нийгэм эдийн засгийн болон хүйсийн хувьд харилцан хоорондоо холбогдож нийгэм хууль зүй сэтгэл санааны хувьд харилцан бие биеийнхээ өмнө хариуцлага үүрэхийг хэлнэ. (Бадамгарав, 2022) Гэрлэлтийн утга учир нь чөлөөт байдал, нийгмийн гэрээ болон ёс суртахуун, шашны үнэн бодит байдал, харилцан хамгаалалт гэсэн 5 түвшнээс бүрддэг бөгөөд тухайн соёл ба цаг үе нөхцөл байдлаа дагаад аль түвшин нь илүү чухалчлагдах эсэх нь ч өөрчлөгдөж байдаг. (Намжил, 2014)

Дүгнэж хэлэхэд, нийгэм соёлын орчны шинжилгээ нь хуримын уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх нь зөвхөн бизнесийн зорилгоос давсан нийгмийн хэрэгцээнд нийцсэн арга хэмжээ болохыг баталж байна.

Орчин үеийн хосуудын уламжлалт соёлын эргэлт болон хотын иргэдийн иргэний үнэт зүйлийн эрэлт нь хуримын аяллын бүтээгдэхүүний тогтвортой эрэлтийн нийгэм-соёлын үндсийг бүрдүүлж байна.

2.1.3 Хүн ам зүйн орчин-Гадаадын жуулчин

Монгол Улсын аялал жуулчлалын салбар сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж байна. Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр 2024 онд 727,400 гадаадын жуулчин Монгол Улсад зорчиж, аялал жуулчлалаас 1.5 тэрбум ам.долларын орлого олжээ.

Засгийн газар 2023–2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласан нь аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, жил бүр 1 сая гадаадын жуулчин татах зорилготой холбоотой юм. Аялал жуулчлалын салбарын суурь бүтээгдэхүүн нь манай улсын хувьд онгон дагшин байгаль, уламжлалт соёл, ёс заншил юм. Монгол Улсын аялал жуулчлалын салбар сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж байна.


Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр 2024 онд 727,400 гадаадын жуулчин Монгол Улсад зорчиж, аялал жуулчлалаас 1.5 тэрбум ам.долларын орлого олжээ. Засгийн газар 2023–2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласан нь аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, жил бүр 1 сая гадаадын жуулчин татах зорилготой холбоотой юм.

Аялал жуулчлалын салбарын суурь бүтээгдэхүүн нь манай улсын хувьд онгон дагшин байгаль, уламжлалт соёл, ёс заншил юм. (Энхбат, 2023)

2015 онд Монгол Улсад ирж буй жуулчдын 46% нь үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтанд татагдаж Монгол улсаар аялдаг байсан бол 2017 онд 36% болж буурсан байна.

Зураг 2.6 МУ-д аялаж буй жуулчдын шалтгаан

Жуулчдын МУ-д аялсан шалтгаан, хувиар



Эх сурвалж: (ХХК, 2016)


Монголын уламжлалт зан заншил, соёлтой танилцахаар ирэх жуулчдын тоо нэмэгдсэн ба 2015 онд 22% байсан бол 2017 онд 30% болж өсжээ. (MIRIM Consulting, 2019) Соёлын аялал жуулчлалын зах зээлд жуулчид үндэсний өв уламжлалыг биеэр мэдрэх, оролцох, суралцах сонирхолтой байдаг.

Иймээс хуримын ёслол нь туршлагад суурилсан аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэхэд тохиромжтой.

Монгол хуримын зах зээлийн боломж дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно:

- Соёлын өвийг үзэх сонирхол өссөн.
- Гэр бүл, зан үйлийн туршлага сонирхдог сегмент бий.
- Фото, видео, контентод суурилсан аяллын эрэлт нэмэгдсэн.
- "Authentic experience" буюу жинхэнэ туршлагын эрэлт өндөр байна.

Зураг 2.7 МУ-д ирсэн жуулчдын тооны харьцуулалт



Эх сурвалж: (ХХК, 2016)

Хүснэгт 2.1 Монгол Улс дахь хуримын аялал жуулчлалын боломжийн тойм

Боломжийн хэмжүүр	Агуулга	Дүгнэлт
Байгалийн тогтоц	Говь, Хөвсгөл, Алтай, тал хээр	Дэлхийд цорын ганц
Уламжлалт зан үйл	Монгол хуримын 4 үе шат	100 жилийн түүхтэй
Өрсөлдөгч байдал	Destination wedding ойрын өрсөлдөгч байхгүй	Анхдагч зах зээл
Зорилтот хос	Жил бүр 727,000 жуулчин	1-2%, 7,000-15,000 хос
Гадаадын зах зээл	Солонгос, Япон, Баруун Европ	Соёлын хурим эрхэмлэдэг
Засгийн газрын дэмжлэг	"Монголд зочлох жил" 2023-2028	Стратегийн нийцтэй

Дүгнэж хэлэхэд, гадаадын жуулчдын тоо тасралтгүй өсч, соёлын аяллын эрэлт нэмэгдэж байгаа нь Монгол хуримыг олон улсын зах зээлд сурталчлах тааламжтай цаг үеийг тодорхойлж байна. Засгийн газрын жил бүр 1 сая гадаадын жуулчин татах зорилготой хөтөлбөр нь тус зах зээлийн суурийг улам бүр өргөжүүлэх нөхцөл болж байна.

2.1.4 Хууль эрх зүйн орчин

Монгол хуримыг аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэхэд дараах хуулийн хүрээ шийдвэрлэх ач холбогдолтой. Хамгийн чухал нь соёлын өвийг хамгаалах хуулийн зохицуулалт, аялал жуулчлалын тусгай зөвшөөрлийн шаардлага, болон хувь хүний мэдээллийн хамгаалалт юм.

Хүснэгт 2.2 Хууль эрх зүйн орчны шинжилгээ

Хуулийн актын нэр	Холбогдох заалт	Нөлөөлөл
"Соёлын өвийг хамгаалах тухай" хууль (2014)	Биет бус соёлын өвийг бүртгэх, хамгаалах, дамжуулах үүрэг тодорхойлно. Зан үйлийг арилжааны зорилгоор ашиглахад ёс зүйн зарчим шаардана.	Өндөр Хуримын зан үйлийг ашиглахад баримтлах стандарт
"Аялал жуулчлалын тухай" хууль (1998, 2019 нэмэлт)	Аяллын бүтээгдэхүүн борлуулах лиценз шаардагдана. Гадаадын жуулчинд зориулсан зохион байгуулалтад тусгай зөвшөөрөл хэрэгтэй.	Дунд Лицензийн зардал, хугацаа
"Гэр бүлийн тухай" хууль (1999)	Гэрлэлтийн бүртгэл заавал шаардагдана. Гадаадын иргэний гэрлэлт тусгай дүрэмтэй.	Дунд Destination wedding хосуудад хамаарна
Монгол Улсын Засгийн газрын "Монголд зочлох жил" хөтөлбөр 2023-2028	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх дэмжлэг, татаас, хэвлэл мэдээллийн нөөц хуваарилагдана.	Маш өндөр Стратегийн нийцтэй, санхүүгийн дэмжлэгийн боломж
ЮНЕСКО-ийн Биет Бус Соёлын Өвийн Конвенц (2003, МУ нэгдсэн 2009)	Уламжлалт зан үйлийг жуулчлалд ашиглахдаа жинхэнэ шинжийг хадгалах, орон нутгийн оролцоог хангах шаардлага тавина.	Өндөр Олон улсын нэр хүндийн дэмжлэг

Хуримын аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хуулийн орчин нь нийт дүгнэлтийн хувьд дэмжлэгтэй буюу "дунд" болон "өндөр" нөлөөлөлтэй байна. Нэн ялангуяа "Монголд зочлох жил 2023–2028" хөтөлбөр нь стратегийн нийцтэй байгаагаас гадна санхүүгийн дэмжлэгийн тодорхой боломжийг бүрдүүлж байна.

Иймд хуулийн зохицуулалтыг зөрчилгүйгээр ажиллах болон олон улсын стандартыг хангах нь хуримын аяллын бүтээгдэхүүний тогтвортой хөгжлийн зайлшгүй нөхцөл болохыг тогтоолоо.

2.1.5 Стратегийн төлөвлөлт

Хүснэгт 2.3 *SWOT* Шинжилгээ - Монгол Хуримын Аяллын Бүтээгдэхүүн

ДАВУУ ТАЛ (Strengths)	СУЛ ТАЛ (Weaknesses)
<ul style="list-style-type: none"> • Дэлхийд өвөрмөц, ижил байхгүй соёлын давтагдашгүй чанар • 13 шат бүхий цогц, утга учиртай зан үйл • Байгалийн өвөрмөц орчин тал хээр, уул ус, цэлмэг тэнгэр • Хэрэглэгчийн эрэлт бодитоор баталгаажсан (91.7%) • Тогтсон хэрэглэгчийн судалгааны мэдээлэл • Олон улсын өрсөлдөгч байхгүй анхдагч зах зээл 	<ul style="list-style-type: none"> • Аяллын бүтээгдэхүүн болгох туршлага хомс • Гадаадад зориулсан маркетинг, брэнд дүр байхгүй • Зохион байгуулалтын стандарт тогтоогдоогүй • Нутгийн мэргэжилтнүүдийн хязгаарлагдмал тоо • Хэлний саад (орчуулгын чанар) • Хүртээмжтэй дэд бүтцийн дутагдал
БОЛОМЖ (Opportunities)	АЮУЛ (Threats)
<ul style="list-style-type: none"> • Destination wedding зах зээл жилд 10.8% өсч байна • "Монголд зочлох жил 2023-2028" хөтөлбөрийн дэмжлэг • Нийгмийн сүлжээний маркетингийн өргөн нөлөөлөл • Зорилтот зах зээл (Солонгос, Япон, Европ) идэвхтэй • Гэр бүлийн аяллын (family travel) сегмент өсч байна • Эко-соёлын аяллын шинэ хандлага дэлхийд нэмэгдэж байна 	<ul style="list-style-type: none"> • Уламжлалт зан үйлийн утга алдагдах эрсдэл • Улирлын хязгаарлалт (зөвхөн зун-намар) • Эдийн засгийн хэлбэлзэл жуулчдын тоог бууруулна • Дотоодын шинэ өрсөлдөгч нэвтрэх боломж COVID-19 шиг дэлхийн хямралын нөлөө • Нутгийн иргэдийн зөвшөөрлийг авахад хэцүү байж болно

Дүгнэж хэлэхэд, стратегийн аюулын хувьд уламжлалт зан үйлийн утга алдагдах эрсдэл, улирлын хязгаарлалт (зун-намар), дотоодын шинэ өрсөлдөгч нэвтрэх боломж зэрэг нь байнгын хяналт шаардах хүчин зүйл болж байна.

Эдгээр аюулын эсрэг "орон нутгийн иргэдийн оролцоог хангах", "мэргэжлийн стандартыг тогтоох", "улирлын бус дотоодын аяллын хувилбар боловсруулах" зэрэг арга хэмжээг урьдчилан тооцооллох нь чухал болохыг тогтоолоо.

Гэсэн хэдий ч тус стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд систем дэмжлэгтэй маркетинг, мэргэжлийн хүний нөөцийн хөгжүүлэлт, чанарын стандартыг тогтоон мөрдөх зэрэг дагалдах арга хэмжээ зайлшгүй шаардлагатай болохыг судалгаа харуулж байна.

2.2 Төв халхын хуримын аялал төлөвлөлт

2.2.1 Монгол хуримын зан үйлийн дэлгэрэнгүй тайлбар

Доорх хүснэгт нь Төв Халхын уламжлалт хуримын 13 үндсэн зан үйлийн бэлгэшээл, оролцогчид, ёс заншил, зан үйлүүдийн дэлгэрэнгүй шинжилгээ юм. Хуримын зан үйл бүр нь зөвхөн ёслол биш, харин соёлын гүн утга, ёс зүй, нийгмийн харилцааг агуулсан өвөрмөц туршлага бөгөөд аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломж өндөртэй.


Хүснэгт 2.4 Монгол хуримын 13 зан үйлийн дарааллын дэлгэрэнгүй

Сүй тавих ёс	
Сүй бол нэг айл өрхийн хүмүүсийн унах унаа, ачих ачилга, идэх хоол гэсэн бүрдлээр хамарна. Сүй нь голдуу мал байсан ба 7-8 бод байх бөгөөд малыг бодоор тоолж бодын сүй өргөдөг. Сүй бол хүүхэн богтлох ёсны нэг хэлбэр бөгөөд хүнийг эд малаар худалдан авдаг эцгийн эрхт ёсны дарангуйллын үлдэц. (Хорлоо, 1999)	
Өндгөн сүй	Гэрлэлтийн сүй
Эртний ураг холбох ёс бөгөөд нэг том язгууртан ноёд түшмэд хүү охиноо нялх цагт нь гэрлүүлэх хэлцэл хийж охин хургатай цагаан хонь, охин унагатай цагаан гүүгээр бэлэг хүргэж цагаан хадгаар сүй тавьдаг ёстой байжээ. (Намжил, 2014)	Ам турших хадгийг тогтоосны дараа эд малаар бэлэг өргөхийг хэлдэг бөгөөд хүргэний талын хэлмэрч нар бэрийн эцгийнд хишиг айлтгахаар эргэж ирнэ. Үүнийг халхчууд “Сүй тавих ёс” гэнэ. (Намжил, 2014)
Бэр гуйх ёс	
Төв халхчууд бэр гуйхдаа сарын сайныг саатан хүлээж, өдрийн өлзийг өнжин хүлээж байгаад хүүгийн эцэг эх нь нэг нутгийн, өөрсдийн сайн мэдэх, удам судар сайтай, элэг бүтэн, сайн сайхан аж амьдралтай, өнөр өтгөн ам бүлтэй, төлөв томоотой 2-3 хэлмэрчийг цагаан буурал, саарал морь унуулан бэрийн эцэг эхийнд очуулахаар илгээнэ.	

Зураг 2.8 *Есөн цагаан тахил*

Тухайн хүний дээш долоон үеийн өвөг дээдэс, эдүгээ амьдарч буй нэг үе болон ирээдүй хойч үедээ хүндэтгэл үзүүлэн тахил өргөх зан үйл юм.

Эрт цагт есөн цагаан хадган дээр есөн мөнгөн аяга байрлуулж, сүү бялхуулан хоймортоо тахил болгон өргөдөг байжээ. Энэ нь ариун цагаан сэтгэл, удам судраа дээдлэх бэлгэдлийг илэрхийлдэг. Бэр гуйх ёс нь зөвхөн эцэг эхээс зөвшөөрөл хүсэж буй хэрэг бус, тухайн хүний өвөг дээдсээс мөн адил гуйж, хүндэтгэл үзүүлж буй утгыг агуулдаг. Шинээр айл гэр болж буй хосыг хүмүүн заяатай, өнөр өтгөн удмыг үргэлжлүүлэгч хэмээн бэлгэшээж, долоон үеийн өвөг дээдэс, одоо үеийн ахмад буурлууд болон ирээдүйд төрөн гарах үр хойчийг бэлгэдэн “есөн цагаан”-аа засаж мөргөн хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай.

Зураг 2.9 *Богтос өгөх*

Өргөө гэрт орж ирэхэд эсгий үүдийг сөхөж эрийн босгоор орж ирэн, гарахдаа эмийн босгоор гардаг байсан нь

“Эрийн нэрээр орж

Эмийн нэрээр гарна” гэсэн үгтэй зохицдог байжээ. Бэрийн тал хэрвээ хүргэн хүүг зөвшөөрвөл богтос чөмөг чанаж бэлдээд хадганд ороон хэлмэрчид буулгаж өгнө. Үүнд нэг хэлэлцээр хийдэг нь хэзээ хуримаа хийх өдрийг товлож нэг, хоёр, гурав намрын дараа хэмээн товлож хурим хийх хугацаанд хамтран амьдарч эр эмийн шинжийг ялган зан зангаа таньдаг бөгөөд

“Аваагүй байхад авгай сайхан

Алаагүй байхад үнэг сайхан” (Монгол хэлний их тайлбар толь, 2016) гэдэг зүйр үг шиг хамтран амьдрах үед ахуй бие болох аж төрөх амьдралын ухааныг нэгэнтээ сорьдог байжээ.

Зураг 2.10 *Сөн нийлэх ёс*

Эх сурвалж: (N news.mn, 2022)


Сөн нийлэх ёс нь монгол хуримын уламжлалт ёслолын нэг бөгөөд бэр, хүргэн талынхан (хоёр тал) өөрсдийн авчирсан айраг, архи, идээг нэгтгэн найрлахыг хэлнэ. Энэхүү ёслол нь хоёр тал ургийн холбоо тогтоож, бэр, эр нөхрийн хайр сэтгэл, сүүн сэтгэлийг илэрхийлэн нэгдэж буйг бэлгэддэг бөгөөд найраа хийн нар жаргахаас урьтаж морддог.

Хуримын бэлтгэлийн үе

Хүргэний тал

1. Хуримын бэлтгэлийн гол ажил нь хүүгийн гэр бэлддэг явдал байдаг агаад тиймээс хүүгийн гэрийг хүү гэрлэхээс худ ураг болохоос хэдэн жилийн өмнөөс бэлдэж болдог.
 Үүнийг гэр бүрлэгийн найр гэх бөгөөд хүргэний тал хийдэг. Тэгэхдээ уламжлалт заншлын дагуу бэрийн тал гэрийн бүслүүр өрх, дотоод тавилгыг өгч бусдыг хүргэний тал дангаар хийдэг. (Нугеe.mn, 2024)
2. Худ бууссаны дараа эл бэлгэ ерөөлтэй их үйлийг дээдлэн хүүгийн тал бэрийн ураг төрлийн хүмүүсийг цайлж, дайлдаг, найрлуулдаг, бэрийн ураг төрлийн бүх хүмүүст бэлэг өгч гарыг нь цайлгадаг. Эл ёсыг “Дээж тавилан” буюу “мах идүүлгэн” хэмээн нэрийддэг.
3. Хүүгийн ээж нэгэн бэлгэтэй өдөр тавгийн идээ архи цэгээтэй, бэрд 2-3 зах дээлийн материал авч очин эсгэж оёж ёсолдог.
 Хүүгийн ээж ор дэрний материалаа ачиж, тавгийн идээтэй очоод ор дэрээ эсгэж оёдог. Голцуу 2-4 давхар байдаг. (Намжил, 2014)

Зураг 2.11 Монгол гэр



Эх сурвалж: (Tourist info center)


Бэрийн тал


1. Бэрээ мордуулахын өмнө ураг төрөл хамаатан саднаар нь айлчлуулдаг агаад түүнийг бэр цайлуулах ёс /цайлах/ ёс хэмээдэг.
 Энэ ёслолд бүсгүйн аав ээж төрөл төрөгсөд ирж оролцох бөгөөд харин хүргэний талаас хүн ирэх ёсгүй.
2. Охиныхоо үс гээгний чимэг, зүүлт, өвөл зуны дээл, ор дэрний хэрэглэл, авдар сав болон эргэнэг, тогоо шанага тавихад зориулалттай эргүүлэг ширдэг дэвсгэр зэргийг хосоор бэлтгэж, эмээл хазаартай морь, хэдэн толгой мал зэргийг инж болгон өгдөг.
3. Охины инжинд орох бэлэг сэлтийг зөвхөн түүний эцэг эх хоёр бэлтгэх бус эрийн талын төрлийн хүмүүс хувь өгч байсан нь эхийн эрхэт ёсны үеийн хэв заншлын ул мөр байж болох юм.

Зураг 2.12 Эсгий ширмэл олбог



Эх сурвалж: (үйлдвэр)

Буйр засах ёс	
<p>Зураг 2.13 <i>Алаг мэлхий</i></p>  <p><i>Эх сурвалж: (Peak tm, 2021)</i></p>	<p>Буйр засах ёс нь зөвхөн шинэ гэр орон сууцаа барихаас гадна “Буу ир” буюу хорвоо ертөнц дээр та өөрийн бэлчээр орон зайтай болох таны амьдралын цар хүрээг хэлнэ.</p> <p>“Ямар цартай хүн бэ?, Энэ их бэлчээртэй хүн шүү, Энэ хүн их цараатай хүн шүү” гэж ярьдагтай адил та хаана ч очсон буйртай хүмүүнийг монголчуудыг ийнхүү хэлж өөрсдийн буйрыг алаг мэлхий өрж засдаг ёстой байжээ.</p>
<p>Алаг мэлхийн толгой /3 шагай/</p>	<p>Алаг мэлхийг засахдаа тухайн хуриман дээр ирсэн хүмүүс дундаас сонгох буюу ураг удмын сонгууль болох мөч бөгөөд өрх гэрийн эзэн болох хүргэн хүү өөрөө сонгож “Ураг удмын манлай болж оюун билэг, мэргэн ухаан элбэг үргэлж ахалж явдаг Дорж та маань ирж талбиж өгнө үү” хэмээн дууддаг аж.</p>
<p>Алаг мэлхийн хүзүү /5 шагай/</p>	<p>“Толгой хаашаа бие тийшээ” гэдэг шиг толгойг биетэй холбон байдаг хүзүүг “Ураг удмаа үргэлж холбож байдаг сэтгэл сайтай Гэрэлээ эгч та маань ирж алаг мэлхийний маань хүзүүг өрж өгнө үү” хэмээдэг.</p>
<p>Алаг мэлхийн урд хөл /8 шагай/</p>	<p>“Аливаа зүйлийг зоримог шийдэж чаддаг та маань биднийгээ бүх зүйлд чиглүүлж хөтөлж явдаг Бат та маань тэмтрэгч урд хөлийг талбина уу”</p>
<p>Алаг мэлхийн мэлмий /2 шагай/</p>	<p>“Ураг удам дотроо хамгийн их алсын хараатай хараа мөхийлгөж, уужуу тайван сэтгэлтэй, аливаа зүйлийг харж чаддаг та маань ирж мэлмий юуг нээж хайрлана уу” гэх зэрэг эрхтэн бүрийг бэлгэшээн буйраа засдаг ёстой байжээ.</p>
Ачлал өргөх ёс	
<p>Хүн амьдралынхаа туршид ганц л удаа ээж аавдаа ачлал өргөдөг нь энэ бөгөөд эрэгтэй хүний баруун өвдөгнөөс нь эмэгтэй хүний зүүн өвдөгнөөс адис авч эцэг эх хоёрынхоо өвдөгнөөс дээш гарахгүй гэж бэлгэшээн амлалт өгч төрүүлж өсгөсөнд нь гялайж, өөрсдийн бүхий л сэтгэлээ илэрхийлж уучлал гуйн хоёр талын амьд сэрүүн байгаа эцэг эхдээ хүндлэл үзүүлдэг хайлсан цайлсан сэтгэл уярсан нандин ёс.</p> <p>Ингэхдээ хадган дээр хоргоо торго, шинэ дээл хийж барин өмсгөж ачлал барьдаг.</p>	

<p>Зураг 2.14 Галын хайч</p>  <p>Эх сурвалж: (toolsmasteruk co uk, n.d.)</p>	<p>Хүүгийн эх нь бэрээ болгохыг зөвшөөрч байвал хадганд ороосон галын хайч болох ахаа ижийг хадганыхаа ороолтыг аван дээр нь хайчаа тавиад бэрдээ гал манах засах эрхийг нь өгч өвлүүлж буйн шинж.</p> <p>Харин үл зөвшөөрвөл хадгийг авч дэлгэлгүй хуримыг зогсоож буйн илрэл ажээ.</p> <p>Энэ тохиолдолд хэрвээ хурим хийхээс урьтаж хүүхэдтэй болсон байвал “гал дээр унасан зээ” гэж ярьдаг тухайн бэрийн төрүүлсэн хүү хүргэний эцэг эх болох өвөө эмээ дээрээ өсөж, өргөж аван өөрсдийн галдаа үлдээдэг ёс байв.</p>
Гал тахиx ёс	
<p>Монголчуудын хуримын ёслолын салшгүй нэг хэсэг нь гал голомтоо бадраах буюу гал тахиx ёс юм. Энэ нь шинэ өрх айлын буян заяаг сахих, гал тэнгэрийг баясгах ариун ёслол гэж үздэг.</p>	
<p>1. Хэн тахиx вэ:</p>	<p>Эцэг талын гэрийн гал голомтоос гал салгаж өөрийн тулгандаа бадраах ёс бөгөөд галыг гэрийн эзэгтэй буюу бэр өөрөө асааж, галын бурхныг баясган мялааж өвчүүгээр тахидаг.</p> <p>“Галын илч халуун дөл, Гаслан бүхнийг ариусгаг, Тэргүүн хишиг дэлгэрүүлж, Тэнгэр бурхан ивээг” (undesten.mn, 2025) хэмээн ерөөл өргөдөг. Шар тос, идээний дээжээр галаа баясгана.</p>
<p>2. Галын нууц:</p>	<p>Эцгийн галын өвөг дээдсийнх нь нууц болох алдар нэр, галтайгаа яаж харьцах дэг соёлуудаас галын манаач болох эх нь бэрдээ тайлж хэлж өгөх нууцын тайлал ба чихэнд шивнэнэ.</p>
<p>3. Ёслолын үйл явц:</p>	<p>Галын хайчаа шар тосоор мялаагаад байгалийн сайхан үнэртэн болох арц ганга, давс, чанаж болгосон шүүс, таван зүйлийн тахил, хүсэл эрдмийн таван зүйл, хонины өвчүү, хонины баруун хаа, идэх ураг саа зэрэг өргөлөө галын эзүүдэд өргөж эрчмээ дуудаж ийнхүү тулгандаа галаа бадраах ёслол эхэлдэг.</p>
<p>4. Гал голомтын ёс:</p>	<p>Гал голомтыг үргэлж цэвэр ариун байлгах ёстой. Галыг гэртээ юм уу гадаа тахиж болно. Энэхүү ёслол нь шинээр гал голомт бадрааж буй хосуудын амьдралд буян хишиг дуудаж, галын тэнгэрээс үр хүүхдийг нь ивээхийг хүсдэг уламжлал юм.</p>

Бэрийн цай чанах ёс

Зураг 2.15 Бэрийн цай чанах ёс



Эх сурвалж: (Өмнөговь, 2026)

Бадраасан гал дээрээ бэр анхны тогоо дүүрэн цайг чанадаг бөгөөд хадаг уясан шанагаар огт асгалгүй гурван удаа нар зөв эргүүлэн самраад уудалж тогоогоо өргөн хүйсийг нь тосоор мялаагаад буцааж эргүүлэн төв тэгш тавьдаг.

Цайгаа чанаад дээжийг нь тэнгэр хангайд өргөж орж ирээд хамгийн түрүүнд нөхөртөө цай аягалж өгөөд дараа нь эцэг эхдээ барьж тэрний дараагаар нь нас ёсны дэсээр шинэ бэрийн гарын цайг ууцгаадаг.

Мөн цайны амтаар нь бэрийг давхар шинждэг. (Сүхбат, 2013)

Саваа бүтээх ёс

Зураг 2.16 Даллагын уут



Эх сурвалж: (Mongolia M., 2023)

Даллагын сав заавал авдар дотор байна.

Даллагын уутыг хундан цагаан хурганы арьсаар хийдэг бөгөөд дэлгээтэй хэлбэрээр нь ирсэн зочид уг арьсыг уул усандаа сэвж даллан нутаг усны эрчим, хишгийг шингээнэ.

Тэгсний дараа гэрийн эзэн өвөртлөн гэртээ орж ирээд бага зэрэг арвай буудай тавин авдар дотроо хадгална.

Хурим хийсний 10 нарны дараа эхнэр нь мэс хүргэлгүй оёж сав хэлбэрт оруулна. Жилдээ нэг удаа галаа тахихдаа бага багаар арвай буудайгаа нэмж хийнэ, өөр зүйл хийдэггүй.

Мөн даллагын уут өвлөгддөггүй бөгөөд эхнэр нөхрийн хамгийн сүүлд насан эцэс болсон нэгнийх нь баруун сүйжин доор нь даллагын уутаа дэлгэн эвж өгч оршуулдаг заншилтай.

Зураг 2.17 Хишигийн сав



Эх сурвалж: (Mongolia T., 2026)

Хишигийн уутан дотор зөвхөн шагай хийдэг бөгөөд уг шагайгаа хүнээс гуйж авдаггүй бас олж авч болдоггүй.

Зөвхөн өөрсдийн эдэлж хэрэглэсэн малын яснаас авдаг, мөн хүмүүсээс хишиг болгон авч болдог.

Хуриман дээр зочид шагайтай ирэх ёстой байдаг бөгөөд уг шагайгаа өөрсдийн хишигийн уутнаас авч ирдэг.

Яагаад шагай өгдөг вэ гэвэл, шагай нь малын хамгийн хатуу яс бөгөөд малын шагайнд газрын эрчим энерги шингэсэн байдаг юм.

Хуримд ирсэн хүмүүс бэлгэнд мал өгөхдөө хадган дээр шагай тавин ямар мал өгөх, хэдэн ширхгийг өгөх зэргийг шагайгаар илэрхийлж хоёр хосыг бялааж шагайгаараа буулган өгдөг байсан.

Тиймээс заавал шагайгаа эхэлж өгдөг ёстой байжээ.

Хишигийн уутаа бэр нь урьдаас оёж бэлтгэж, гэрийн эзэн нь хишиг болгож авсан шагайгаа уутандаа хийн хадгална. Даллагын савнаас ялгаатай нь уг уут нь үе дамжин үлддэг бөгөөд гэрийн эзэн отгон хүүдээ өвлүүлэн үлдээдэг заншилтай.

Найрын ёс

Найрлан цэнгэнэ гэдэг нь цугларсан эрчмээ энергээ өөрсдөдөө дуу хөг аялгуу, ерөөл магтаалаар мялаан шингээдэг. Уулзаагүй удсан ураг төрөл ах дүү нар хамгийн багадаа 3 өдөр найрладаг байсан.

Шинээр айл болсон гэртээ зочид нэг хонодог байсан бөгөөд эхнэр нөхөр нь хөх өнгийн хос дээл өмсөн хуримладаг байжээ. (Сүхбат, 2013)

Найрын суудлын дэг ёс

Бага үдийн эхээр найраа эхэлж, наран жаргангуут дуусгадаг байжээ. Найр хуримд ирсэн уяан дээр хүндлэн хүлээн авч гэртээ залж оруулан, цай идээ барьж, тамхилалцан, мэнд усаа мэдэлцсэний дараа ахмад голцуу тэргүүн хүндэтгэлт хүмүүс ирсний дараа найраа эхэлдэг. Найрт ирэгсэд нь гоё ганган хувцсаа өмсөж, сайн хувцсаа өмсөж хурим найрт их л хүндэтгэл үзүүлдэг заншилтай. Гэрт найр эхлэхэд эрэгтэйчүүд нь насны дарааллаар бар суудлаас баруун хотовч хүртэл зээглэн зэрэгцэж суудаг бол эмэгтэйчүүд нь туулай суудлаас ахмадын зэрэглэлээр суудлаа эзлэн найр эхлэхэд бэлэн болдог. (Сүхбат, 2013)

Найрын ёслолын үйл явц

Найрыг голлон удирдах ахлагчийг томилж найр удирдахыг гэрийн эзнээс хүсэж хултай айраг барьдаг. Найрыг удирдагч найрлагсад гурван жүнз архи барьж гурав гурван хул архи барьсны дараа найрын ерөөлийг ерөөлчөөс дэвшүүлэхийг хүснэ. Найр удирдагч дуучид, хөгжимчдийг найрын дугараа дууг эхлэхийг хүснэ. Найрыг голцуу төрийн дуугаар эхэлдэг.

	<p>Найрчид дууны завсарт түрлэг өргөн, өргөн олноороо дуулан цэнгэдэг уламжлалтай байжээ.</p> <p>Хурим найрыг төгсгөхийн өмнө мах шүүсийг дамжуулж, хүн болгонд амсуулан найрын төгсгөлийн дууг аялахыг дуучнаас хүснэ.</p> <p>Энэ дууны дугараа дууссаны дараа найрчид үүдэн талаасаа эхлэн гадааллаж найр сайхан болсныг бэлгэдэлтэй үгээр хэлэлцэн гэрийн зүг мордон явцгаадаг эртний сайхан уламжлалт ёс байжээ. (Сүхбат, 2013)</p>
Найрын дууны ёс	<p>Монголчууд найр эхэлж, төгсгөдөг тогтсон дуутай.</p> <p>Хуримд найр нь 32 аяын “Түмний эх” дуугаар эхэлж дэс аясаар дуу хуурыг дугараа барьцгаан ерөөлчөөс “Гэрийн ерөөл”, “Сархадын ерөөл” хэлнэ.</p> <p>Халх их хурим бол төдий л урт сунжирдаггүй уртын дууны арван түрлэг, морин хуурын арван татлагаар хурим найр дуусах ба их хуримд завхай богино дуу дуулах, шог ярихыг хориглодог эртний заншилтай.</p> <p>Их хурим нар унины үзүүрээс мултармагц “Хариад явчаасай гэсэндээ биш Ханилан суух сандаа гэсэн ч Халхчуудын дүрэм байна Харьсан хойно санаа амрах нь ээ”</p> <p>Гэж найр өндөрлөх ерөөл тавьж буцахын хундага гурав гэдгээр хундага өргөн “Хөхөө шувуу”, “Нарийн шарга” дуугаар үдэлтийн ая барьж их хурим өндөрлөдөг заншилтай. (Сүхбат, 2013)</p>
Гэрийн ерөөл	<p>Гэрийн ерөөлд шинэ гэрийг магтахын зэрэгцээ “Хүрэн хөлгүүдийн тоос нь огторгуйд хандсан Хар бараан адуун сүрэг чинь Хангай говийг дүүртэл бүрхсэн Үржилтэй тэмээн сүрэг чинь”</p> <p>Гэж таван хошуу малыг магтдагаараа онцгой бөгөөд шинэ айлын баян чинээлгийг бэлгэджээ. (Хорлоо, 1999)</p>
Сархадын ерөөл	<p>Зөвхөн архи шимийг магтах бус идээ цагаагаар цацал өргөж тэнгэр, уулс, усыг тахихыг заасан нь эртний уламжлал болохыг тодотгосон байна. (Хорлоо, 1999)</p>

Булангийн найр

Тус найр бол хүргэн бэр унтах үед болох төрөл төрөгсөд оролцдоггүй үеийн залуучуудын найр юм.

Энэ найран дээр “үхэр уяж гаргах” ёслол үйлдэж “халуун шавайд хэлэх үг” гэдэг тусгай үг бий.

Найзын найр бол гол худ худгуй, дараа худ худгуй, мөргүүлсэн эцэг эх зэрэг гурван худын хамтарсан найз нөхдийн найр юм.

Найзын найрын дараа хариу хурим хийж “ирсэн шувуу явж, орсон бороо арилдаг ёстой” гэж охины талынхныг мордуулна.

Худ мордоход гадна ширээ тавиад хүүгийн талын бэргэн түрүү худад 3 хэм барина.

Түрүү худ түүний нэгийг нь тэнгэрт өргөж нөгөөг нь газарт өргөөд үлдсэн нэгийг нь өөрөө уугаад хундагыг өвөртлөн зугтахыг завдана.

Хэрвээ зугтаавал бэргэн аргалаар шиднэ. Баасанд оногдвол муу гэж оногдохгүй зайлан зугтахыг хичээнэ.

Тохмын найрт хүүгийн талын хуримд үйлчилсэн бүх хүмүүсээ суулган найрлана.

Үүнд хүүгийн талын үйлчилсэн бүх хүмүүст талархлаа илэрхийлж хүү бэр архи хадаг барьж бүгдэд мөргөнө. Мөн хүн бүрд дайлаар хавтага, хадаг зэрэг гар бэлэг өгөх ёстой (Сампилдэндэв 1997, 174-178).

Найрын цээрлэх ёс

Монгол хурим найрт хатуу баримтлах ёс зарчим бол найрын дэг журам билээ.

Үүнд:

1. Найр хурим эхлэхэд эрэгтэй нь гэрийн баруун эмэгтэй нь зүүн талаар найр эхлэхээс өндөрлөх хүртэл байраа солихгүйгээр суудаг
2. Хэрэв найрын үед гарах бол заавал зөвшөөрөл авч гараад орж ирээд байрандаа суудаг. Морь харахаас/бие засах/ өөр байдлаар гардаггүй.
3. Найрыг найрын ахлагч/дарга, даамал/ удирдан явуулдаг
4. Найр эхлэхээс дуусах хүртэл нэг дуулсан дуугаа давтан дуулдаггүй.
5. Найр эхлэх, найр жаргаах дуу гэж байдаг
6. Дуу дуулж байхад ялангуяа найрын магнай дуу /эхлэх/ дуулж байхад найрын гэрт ордоггүй, дуулж дуусахад нь ордог ёстой.
7. Найр ая бариагүй хүнийг 108 дуу дуулж сурахыг даалгадаг байснаас үзэхэд 108-аас доош дуу мэддэггүй хүн найрт очдоггүй байсан бололтой
8. Найр заавал ерөөлтэй байдаг.

Монгол туургатан, өвөл хавар найрлаж хуримладаггүй, зөвхөн найр хуримыг зун намар хийдэг ёстой. (З.Одбагмэд, 2001)

2.2.2 Монгол хуримын дэлгэрэнгүй хөтөлбөрийн төлөвлөгөө

Хүснэгт 2.5 Үйл ажиллагааны төлөвлөгөө

Цаг	Шат	Үйл ажиллагааны агуулга	Оролцогчид	Хоол ундаа	Тэмдэглэл
1-Р ӨДӨР - Бэлтгэл ба Сүй тавих (Хуримын өдрийн өмнөх өдөр)					
08:00-09:00	Угталт	-Жуулчид хуримын байршилд ирэх, -Мэнд мэдэх ёс, хөөрөглөх ёсоор хүндлэж, айраг цагаан идээгээр угтах -Хуримын зөвлөх (хөтөч) танилцуулга хийх	Хуримын зөвлөх, орчуулагч, угтагч (дээлтэй 2 хүн)	Аарц, ааруул, бяслаг, айраг, цай Цагаан идээ,	Дээл өмсгөх боломж
09:00-10:30	Бэр гуйх ёслол эхлэх	-Хэлмэрчид бэрийн айлд хадаг барин очих ёслол. -Есөн цагааны тахилын тайлбар. -Жуулчид хадаг барих дасгал хийнэ. -Хоёр айлын холбоо тогтоох утгыг дэлгэрэнгүй тайлбарлана.	Хэлмэрч (2-3), ерөөлч, бэрийн эцэг эх, жуулчид цагаан буурал, саарал морь	цагаалга, айраг	Фото зураг авах, видео бичлэг хийх
10:30-12:00	Сүй тавих ёс	-Хүргэний тал малаар сүй өргөх ёслол -Ерөөлийн шүлэг, хадгийн утга тайлбарлах -Бод малыг харах боломжтой	Хоёр талын эцэг эх, хэлмэрч, малчид, жуулчид		Тэмээ, морь харах
12:00-13:30	Үдийн хоол	Уламжлалт монгол хуримын үдийн идээ байх ба хоолны нэр (тавгийн идээ, өвчүү) хэрхэн бүтдэг ямар шидтэйг тайлбарлах	Бүх оролцогчид, жуулчид	Монгол хоол/сонг олтоор	Хоолны соёлын лекц
13:30-15:00	Буйр засах ёс	Шагайгаар алаг мэлхий өрөх ёслол Толгой, хүзүү, урд хөл, мэлмийн бэлгэдлийг тайлбарлах	Хурим ахлаач, ураг удмын ахмад, жуулчид	Мах, цагаан идээ	Шагай тоглоом тайлбар

Цаг	Шат	Үйл ажиллагааны агуулга	Оролцогчид	Хоол ундаа	Тэмдэглэл
15:00-16:30	Сөн нийлэх ёс	Хоёр айлын идээ айраг нэгтгэх ёслол. Жуулчид хоёр айлын нэгдэлд гэрч болно. Айргийн гарал, үйлдвэрлэлийн тайлбар.	Хоёр айлын гэр бүл, хурим зочид, жуулчид	Айраг, Цагаан идээ, цай банш, нэрмэл архи	Айраг амталгаа
16:30-18:00	Соёлын хөтөлбөр	Морин хуурын тоглолт. Уртын дуу сонсох, богино хэлбэрийн гарал тайлбар. Монгол хувцасны түүх, дэл зүүлт, гутлын утга тайлбарлах. Дээл өмсгөлийн туршлага.	Морин хуурч, уртын дуучин, загвар зохион байгуулагч		Хөгжмийн тайлбар
18:00-20:00	Оройн найр	Хуримын өдрийн өмнөх найр эхлэх. Ерөөлч найрын ерөөл тавих. Монгол хоол идэж, айраг, архины соёлын тайлбар. Жуулчид дуунд оролцож болно.	Бүх гэр бүл, жуулчид, дуучид, ерөөлч, бүжигчид		Найрын дугараа наадгай
2-Р ӨДӨР - Хуримын Үндсэн Ёслол (Их Хуримын Өдөр)					
07:00-08:00	Үүр цайх зан үйл	Гал бадраах ёслол эртлэн босч гал асаах. Бэрийн гал тахилгын бэлтгэл ажиглах. Өглөгийн ерөөл сонсох, нарны мэнд өргөх.	Бэр, хадам эх, хурим удирдагч, жуулчид (сонирхсон)	-Хагаасан мах, аарц, айраг -Найрын дээд идээ -Сүүтэй цай, аарц, ааруул -Тавгийн их идээ, -Архи, айраг, жигнэмэг	Нарны мандахыг харах
08:00-09:30	Гал тахиж ёс	Бэр гал асааж тахиж ёслол. Галын хайчийг шар тосоор мялаах. Арц, давс, тахилын өргөл бэлтгэх. Хадам эхийн 'Галын нууц' шивнээ. Жуулчдад галын тахилын дуу хуур тайлбарлах.	Бэр, хадам эх, хурим ахлагч, ерөөлч, жуулчид		Галын ерөөл тайлбар
09:30-11:00	Хүүхэн мордуулах	Охиныхоо гэрт бэр зугтах дүр. Бэр булаалдах нааш. Монгол дээл өмсгөлийн үзэсгэлэн. Охиноос ах дүүтэй нь салах харамсалт үе дуу гунигтай хэсэг.	Бэр, охины ах дүү, хүргэний хамтрагчид, нутгийн залуус		Хошин хэсэг
11:00-12:30	Хуримын замын ёс	Морьтой хоёр тал хуримын зам дагуу явах. Арьс татах, өвчүү цахих, таваг цохих уралдаан. Шагай чөмөг хөөх нааш. Гэрэл зургийн шилдэг үе монгол тал хээрийн дэвсгэртэй.	Хоёр талын залуу найзууд, морьчид, жуулчид (тэргэнцэрт)		Гэрэл зургийн тусгай хэсэг
12:30-14:00	Бэр мордуулах /Бэр мөргүүлэх	Хүргэний гэрт бэр ирж мөргүүлэх ёслол. Ачлал өргөх ёслол өвдөгнөөс адис авах нандин ёс. Хадам эхийн ахаа ижий (галын хайч) шилжүүлэх. Жуулчдад бэлгэдлийн тайлбар дэлгэрэнгүй хийх.	Бэр, хүргэн, хадам эцэг эх, хурим ахлагч, жуулчид		Сэтгэл хөдөлгөм хэсэг
14:00-15:00	Бэрийн цай чанах ёс	Бэр анхны цайгаа нар зөв гурван удаа самрах. Нөхөрт, эцэг эхэд, ахмадуудад аялах дэс дараалал. Жуулчид цай чанах дасгал хийх, монгол цайны онцлог тайлбарлах.	Бэр, нөхөр, хадам эцэг эх, ахмадууд, жуулчид		Цай чанах
15:00-16:00	Саваа бүтээх ёс	Даллагын сав, хишгийн уутны тайлбар. Жуулчид шагай өгөх ёслол. Шагайны тоо, бэлгэдэл тайлбарлах. Урлалын дэлгүүр шагай, дээлийн хэлхээ.	Бэр, хурим зочид, жуулчид, нутгийн урлагчид		Сувенир худалдан авах
16:00-19:00	/Их Хурим/	Хуримын үндсэн найр эхлэх. 'Түмний эх' уртын дуугаар нээлт. Найрын 32 аяны дугаарт морин хуур, хуур	Бүх зочид, найр ахлагч, ерөөлч, морин		Уртын дуу

Цаг	Шат	Үйл ажиллагааны агуулга	Оролцогчид	Хоол ундаа	Тэмдэглэл
		хуурдах. Ерөөлч Гэрийн ерөөл, Сархадын ерөөл тавих. Жуулчдад ерөөлийн хэсгийн орчуулга дамжуулах.	хуурч, дуучид, жуулчид		дуулах дасгал
19:00-21:00	Булангийн найр	Залуучуудын буланд хийх тусгай найр. Үхэр уяж гаргах ёслол. Монгол ардын дуу, бүжиг жуулчид оролцоотой. Нааш-наадгай, аялгуу, шог яриа.	Хурим зочдын залуус, жуулчид, дуучид, зурагчид		Хамгийн баяртай хэсэг
3-Р ӨДӨР - Эргэлтийн Найр ба Мөр Бүтээх Ёс					
09:00-10:30	Эргэлтийн найр	Охины талынхан гурав хоногийн эргэлтэд ирэх. Мордуулах ерөөл Ирсэн шувуу явж, орсон бороо арилдаг. Худ мордоход 3 хэмийн ёс. Гадна ширээнд хундага өргөх.	Хоёр талын гэр бүл, жуулчид, хурим ахлагч	Эргэлтийн дайлагын хоол, цай, боов, мах, аарц	Гэр бүлийн нандин үе
10:30-12:00	Мөр бүтээх ёс	Охины ах дүү бэр дүүгийнхээ хөлдөнгийг авч шинэ гэр рүү очих. Бэрийн шинэ гэр дэх амьдралын дэгийг тогтоох зан үйл. Жуулчдад нэгтгэн дүгнэх ярилцлага, асуулт-хариулт.	Охины ах дүү, бэр, хүргэн, хурим ахлагч, жуулчид		Ярилцлага, дүгнэлт
12:00-13:30	Үдийн хоол	Хуримын сүүлийн хоол хамтдаа идэх. Жуулчдад тусгай монгол нэрийн гэрчилгээ гардуулах. Мэдлэгийн асуулт-хариулт тоглоом. Аяллын сэтгэгдэл цуглуулах.	Бүх оролцогч, жуулчид, хөтөч	Бүтэн хоол: цуйван, шөл, боов, цай	Гэрчилгээ гардуулах
13:30-15:00	Хуримын дараах соёлын хөтөлбөр	Жуулчдад зориулсан монгол гар урлалын туршлага шагай урлал, хилэн зүйлс. Монгол хоолны жор сурах товч хичээл. Сувенир болон гар бэлэг худалдан авах.	Жуулчид, нутгийн гар урлагчид, хоол зохиогч	Жигнэмэц, нарийн боов Замын цай, боов	Гар урлалын туршлага
15:00-16:00	Мордолт	Жуулчдыг уламжлалт мэндчилгээгээр үдэх. Аяллын хөтчийн эцсийн тайлбар, зөвлөмж. Хуримын дурсгалын гэрэл зураг, видео хадгалах хамтын цаг.	Жуулчид, хөтөч, утгагч баг		Дурсгалт гэрэл зураг

Хүснэгт 2.6 Аяллын багцын нарийвчилсан зардлын задаргаа

Зардлын бүрэлдэхүүн хэсэг	Нэгж	А: Үндсэн (1 өдөр)	Б: Стандарт (3 өдөр)
1. Байршил, орон сууц			
Гэр (Хот дотор)	хоног/ хүн	\$20-\$35	\$60-\$105
Гэр (Хөх отог)		-	\$35-\$60
Гэр (Тэрэлж, Хангай)		-	\$100-\$200
2. Тээвэр, логистик			
УБ-байршил (бага оврын машин, 5 хүн)	нэг удаа	\$60-\$80	\$120-\$160
УБ-байршил (дунд оврын машин)		\$80-\$120	\$160-\$240
Морь/гэмээ хөлслөх		\$10-\$20	\$10-\$20

Зардлын бүрэлдэхүүн хэсэг	Нэгж	А: Үндсэн (1 өдөр)	Б: Стандарт (3 өдөр)
3. Зан үйлийн зохион байгуулалт			
Хурим удирдагч, ерөөлч	өдөр	\$50-\$80	\$150-\$240
Морин хуурч + уртын дуучин		\$40-\$60	\$120-\$180
Гал тахилгын материал		\$15-\$25	\$20-\$30
Дээл, хадаг зэргийн зардал		\$50-\$100	\$100-\$200
Гэр барих буулгах ажилчид		-	\$80-\$120
4. Хоол идээ			
Уламжлалт монгол хоол	хэсэг	\$15-\$25	\$45-\$75
Айраг, цагаан идээ		\$5-\$10	\$10-\$20
Тогоочдын цалин (2-4 хүн)		\$30-\$50	\$60-\$90
5. Гэрэл зургийн баг			
Гэрэл зурагчин	хэсэг	\$50-\$100	\$150-\$300
Дрон		-	-
Альбом		\$30-\$50	\$80-\$150
Видео монтаж		-	\$100-\$200
6. Маркетинг			
Онлайн маркетинг (Google, Meta)	сар	-	\$300-\$500
Хуримын аяллын брошюр, гарын авлага	хэвлэл	\$50-\$100	\$100-\$200
Даатгал (жуулчид)	хүн	\$5-\$10	\$10-\$20

Хүснэгт 2.7 Дэлхийн destination wedding үнийн харьцуулалт

Зардлын ерөнхий ангилал	А: Үндсэн хөтөлбөр (1 өдөр)	Б: Стандарт хөтөлбөр (3 өдөр)
Байршил & орон сууц (10 хүн)	\$200-\$350	\$500-\$900
Тээвэр & логистик	\$80-\$120	\$200-\$400
Зан үйл, ёслол, уран бүтээлчид	\$200-\$350	\$600-\$1,000
Хоол идээ (10 хүн)	\$200-\$350	\$600-\$900
Гэрэл зураг & видео	\$80-\$150	\$330-\$650
Маркетинг & захиргааны зардал	\$50-\$100	\$150-\$300
Компанийн ашиг (20-30%)	\$160-\$280	\$480-\$830

2.2.3 Оролцогчдын үүргийн хуваарилалтын менежмент

Аяллын хөтөлбөрийн чанар нь оролцогч хүмүүсийн бэлтгэл, мэдлэгт шууд хамаарна. Нутгийн иргэд, ахмад дээдэс, уран бүтээлчид хамгийн чухал нөөц бөгөөд аяллын бүтээгдэхүүнийг жинхэнэ болгодог гол хүчин зүйл юм.

Хүснэгт 2.8 Оролцогчдын үүргийн хуваарилалтын менежмент

Нэршил	Хэн байх вэ	Гүйцэтгэх үүрэг	Тоо	Тэмдэглэл
Хурим Ахлагч (Найрын Дарга)	Нутгийн ахмад эрэгтэй, хуримын уламжлалыг сайн мэдэх хүн	Найрыг эхлүүлэх, дуусгах, ерөөлч, дуучдыг удирдах, суудлын дэгийг хянах, зочдыг хүлээн авах	1	Хамгийн чухал хүн
Ерөөлч (Хэлмэрч)	Монгол ерөөл, аман уламжлал мэдэх ахмад хүн	Бэр гуйх, сүй тавих, гал тахиx, найрын ерөөлүүдийг тавих, цэцэн үг хэлэх	2-3	Заавал байх шаардлагатай
Морин хуурч	Мэргэжлийн хуурч, хуримын дуунуудыг мэдэх	Найрын 32 ая дуулах, хуримын ая гаргах, жуулчдад хуурын тайлбар хийх	1-2	Уртын дуучинтай хамт
Уртын дуучин	Уртын дуу мэргэшсэн дуучин	Найрын нээлт, 'Түмний эх', хурим дуусгах дуу дуулах, жуулчдад дуу зааж болно	1-2	Эмэгтэй/эрэгтэй аль аль нь
Аяллын хөтөч (Орчуулагч)	Монгол хурим, соёлыг сайн мэдэх, гадаад хэл мэддэг хүн	Зан үйл бүрийн утгыг орчуулах, жуулчдад асуултад оновчтой зөв хариулах, ёслолын дарааллыг тайлбарлах	1-2	Англи болон бусад хэл
Хуримын гэр барих хүмүүс	Нутгийн туршлагатай малчид	Жуулчдын өмнө уламжлалт гэр барих, гэрийн бүрдлүүдийг тайлбарлах, гэрийн тор, хөшигний тайлбар	5-6	Шинэ гэр барих ёслолд
Монгол хоолны тогооч	Уламжлалт монгол хоол мэддэг тогооч	Бүтэн хонь бэлтгэх, тавгийн идээний дараалал хадгалах, дэс дарааллын дагуу ариун цэврийг сахиж ажиллах	3-4	Хоолны аюулгүй байдал
Гэрэл Зурагчин- Видеограф	Монгол соёлын зураглал, байгалийн зургийн туршлагатай	Зан үйл бүрийг баримтжуулах, жуулчдад зориулсан онцлох үзэгдлийг зурах, дурсгалт цомог бэлтгэх	1-2	Зан үйлийн ариун байдлыг хүндэтгэх
Эрүүл Мэндийн Туслах	Анхны тусламжийн мэдлэгтэй хүн	Гэнэтийн өвдөлт, хоолны харш урвал, байгалийн нөхцөлөөс үүдэх асуудалд бэлэн байх	1	Хууль ёсны шаардлага

Хөтөлбөрийн бүтэц нь буйраа засах ёсноос эхлэн, ачлал өргөх ёс, гал тахиx ёс, бэрийн цай чанах ёс, саваа бүтээх ёс, найрын ёс, булангийн найр гэсэн дарааллаар үргэлжлэх нь зан үйлийн логик дарааллыг хадгалахын зэрэгцээ зочдод нэг өдрийн хугацаанд Монгол хуримын гол шатуудыг биечлэн мэдрэх боломжийг олгодог байна.

Мөн гурван өдрийн дэлгэрэнгүй загвар нь хуримын зан үйлийн нарийн дэгийг хадгалахын зэрэгцээ зочдын хэрэгцээг тусгасан тайлбар, орчуулга, оролцооны цагийг тодорхой тусгасан нь бүтээгдэхүүний зарим бэлэн байдлыг нотолж байна. Гэсэн хэдий ч хөтөлбөр нь туршилтаар нотлогдоогүй байгаа тул хэрэгжүүлэлт, зочдын эргэх холбооны шинжилгээ дараагийн шаардлагатай алхам болохыг тогтоолоо.

Дүгнэж хэлэхэд, Монгол хуримын хөтөлбөрийн дэлгэрэнгүй загвар нь нэг өдрийн болон гурван өдрийн хоёр хувилбараар боловсруулагдсан нь зорилтот хэрэглэгчийн ялгаатай хэрэгцээ, зарцуулах чадамжид нийцэхүйц уян хатан байдлыг хангаж байна. Хөтөлбөрийн бүтэцд уламжлалт ёслолын дэг журмыг алдагдуулахгүйгээр аяллын

бүтээгдэхүүний шаардлагуудыг нийцүүлж чадсан нь ажлын онол-практикийн хувь нэмрийн гол бүрэлдэхүүн болж байна.

2.3 Хөтөлбөр хөгжүүлэлт ба боломж

2.3.1 Хэрэглэгчийн судалгаа

Энэхүү судалгааг уламжлалт монгол хурим болон уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгох боломжийн талаарх иргэдийн хандлага, санал бодлыг тодорхойлох зорилгоор явуулсан болно. Судалгаанд нийт 109 хүн оролцсон бөгөөд Google Forms цахим платформоор явуулав.

I-р хэсэг: Ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэй оролцогчдын хувь давамгайлж байгаа нь хурим, гэр бүлтэй холбоотой асуудалд эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоотой уялдаатай гэж үзэж болно.

Оролцогчдын насны бүтцийг харвал 18–24 насны залуучуудын бүлэг хамгийн өндөр хувийг буюу 44 хүн (40.4%) эзэлж байна. Энэ нь залуучуудын эзлэх хувь давамгайлж байгаа нь уламжлалт соёлд хандах залуу үеийн хандлагыг судлахад чухал ач холбогдолтой.

Гэрлээгүй оролцогчдын давамгайлал нь ирээдүйд хурим хийх боломжтой бүлгийн хандлага, сонирхлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Зураг 2.18 Судалгааны ерөнхий мэдээлэл



Оролцогчдын байршлыг авч үзвэл дийлэнх нь буюу 87 хүн (79.8%) Улаанбаатар хотод амьдардаг байна. Судалгааны оролцогчдын ихэнх нь нийслэлийн иргэд байгааг үр дүнг тайлбарлахад харгалзан үзэх шаардлагатай.

II-р хэсэг: Хурим хийх төсөөлөл

Судалгаанд оролцогчдоос хурим хийхдээ ямар хэлбэрийг илүүд үзэх талаар асуухад оролцогчдын 64.2% буюу 70 хүн уламжлалт болон орчин үеийн хосолсон хэлбэрийг илүүд үздэгээ илэрхийлэв.

Бүрэн уламжлалт хурим хийхийг хүссэн 20 хүн (18.3%), голчлон уламжлалт хэлбэрийг хүссэн 10 хүн (9.2%) байгаа бөгөөд эдгээрийг нэгтгэн авч үзвэл нийт оролцогчдын 91.7% нь уламжлалт элемент агуулсан хурим хийхийг хүсч байгаа нь тодорхой болж байна.

Уламжлалт хурим хийхийг хүсэх шалтгааны талаарх олон сонголтын асуулгад хамгийн олон хүн буюу 66 хүн (61.7%) өвөг дээдсийн уламжлал, ёс заншлыг хүндэтгэхийг гол шалтгаан болгон дурдсан нь тэргүүлж байна. Эдгээр үр дүнгээс харахад иргэдийн уламжлалт хурим хийх хүслийн үндэс нь соёлын бахархал болон өвгийн уламжлалыг хүндэтгэх сэтгэлзүй дээр суурилж байгаа нь тодорхой байна.

Уламжлалт хурим хийхэд тулгардаг гол бэрхшээл нь мэдлэг мэдээллийн дутагдал болон мэргэшсэн зохион байгуулагч байгууллагын хомсдол байгаа нь тодорхой болж байна.


Уламжлалт үндэсний хуримын ёс заншлыг хэр сайн мэддэг тухай асуулгад 60 буюу 55% нь мэдлэгийн түвшнээ дундаж гэж үнэлсэн нь хамгийн өндөр хувийг эзэллээ. Сайн мэдэх гэж хариулсан нь 26 хүн (23.9%), маш сайн мэдэх гэж хариулсан нь 12 хүн (11%), мэдэхгүй гэж хариулсан нь 11 хүн (10.1%) байсан байна.

Иргэдийн 65% орчим нь уламжлалт хуримын ёс заншлыг дундаас дооших түвшинд мэддэг байгаа нь мэдлэг мэдээллийн дэмжлэгийн бодит хэрэгцээг харуулж байна.

Уламжлалт хурим хийхэд хамгийн чухал гэж үздэг зүйлсийн талаарх олон сонголтын асуулгад 109 оролцогч хариулсан байна. Эдгээр үр дүнгээс харахад уламжлалт хурим зохион байгуулах үед дээл хувцас, найрын дэг ёс, ерөөл магтаал зэрэг биет болон биет бус өвийн элементүүдийг иргэд онцгойлон чухалчилж байгаа нь тодорхой байна.

Уламжлалт хурим зохион байгуулах мэргэшсэн компани байвал дэмжих эсэх талаар асуухад нийт 109 оролцогчийн 69 буюу 63.3% нь тийм гэж хариулсан нь зах зээлийн эрэлт өндөр байгааг тодорхой харуулж байна. Үгүй гэж хариулсан нь ердөө 3 хүн буюу 2.8% байлаа.

Зураг 2.19 Судалгаанд оролцогчдын хуримын төсөөлөл



III-р хэсэг: Үйлчилгээ ба зардал

Уламжлалт хурим зохион байгуулах компаниас юуг хамгийн их хүсэх тухай олон 74.1% буюу 80 хүн гэр, хувцас, хоол болон ёслол бүгдийг багтаасан бүрэн үйлчилгээний багцыг хамгийн их хүсч байна.

Хэрэглэгчид нэг дороос бүх зүйлийг шийдвэрлэдэг цогц үйлчилгээг хамгийн их эрэлхийлж байгаа нь тодорхой байна.

Уламжлалт хурим зохион байгуулахад зарцуулах боломжтой нийт дүнгийн талаар хамгийн олон хүн буюу 43 хүн (39.4%) 7-15 сая төгрөгний хүрээнд зарцуулах боломжтой гэж үзжээ.

Дундаж хэрэглэгчийн зарцуулах чадвар 7-15 сая төгрөгт байгаа нь үйлчилгээний үнийн бодлогыг тодорхойлоход чухал суурь мэдээлэл болж байна.

Хурим дээр урих зочны тоог тодруулах асуулгад 40 хүн (37%) 50-100 зочин урих төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлэв.

Дундажаар 50-200 зочин урих хэрэгцээ давамгайлж байгаа нь үйлчилгээний хүчин чадал болон байршлын шаардлагыг тооцоолоход чухал үзүүлэлт болж байна.

Зураг 2.20 Судалгааны үйлчилгээ болон зардлын дэлгэрэнгүй




IV-р хэсэг: Аялал жуулчлал ба соёл

Уламжлалт хурим гадаадын жуулчдад сонирхолтой байж болох эсэх талаар асуухад нийт 109 оролцогчийн 50.5% буюу 55 хүн маш их сонирхолтой байж болно гэж үзсэн байна. Сонирхолтой байж болно гэж хариулсан 27 хүн (24.8%), магадгүй гэж хариулсан 23 хүн (21.1%), тийм ч сонирхолтой биш гэж үзсэн 2 хүн (1.8%), огт сонирхолгүй гэсэн 2 хүн (1.8%) байсан байна. Нийт оролцогчдын 75.3% нь уламжлалт хурим гадаадын жуулчдад сонирхолтой буюу маш их сонирхолтой байж болно гэж үзсэн нь соёлын аяллын бүтээгдэхүүн болгох боломжийг тодорхой баталж байна.

Уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгох нь монгол соёлыг сурталчлахад хэрэгтэй эсэх талаар асуухад 108 оролцогч хариулсан байна. Оролцогчдын 41.7% буюу 45 хүн чухал, 31.5% буюу 34 хүн маш чухал гэж хариулснаар нийт дүнгийн 73.2% болж байна. Магадгүй гэж хариулсан нь 27 хүн (25%), тийм ч чухал биш гэж үзсэн нь ердөө 2 хүн (1.9%) байна. Иргэдийн дийлэнх нь уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгох нь монгол соёлыг олон улсад сурталчлахад тустай гэж үзэж байгаа нь соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогод иргэний дэмжлэг өндөр байгааг харуулж байна.

Уламжлалт зан үйлийг үр хойчдоо дамжуулах нь чухал эсэх талаар асуухад 108 оролцогч хариулсан байна. Нийт оролцогчдын 65.7% буюу 71 хүн маш чухал, 29.6% буюу 32 хүн чухал гэж хариулснаар нийт дүнгийн 95.3% болж байна. Магадгүй гэсэн хариулт 4 хүн (3.7%), тийм ч чухал биш гэсэн хариулт ердөө 1 хүн (0.9%) байсан байна. Энэ үр дүн нь соёлын өвийн хадгалалт болон дамжуулалтын талаар иргэдийн дотоод хүсэл эрмэлзэл нийгэмд хүчтэй байгааг баталж, уламжлалт хуримын ёслолыг хадгалж хөгжүүлэх нь нийгмийн хэрэгцээнд нийцэж буйг илтгэж байна.

Зураг 2.21 Аялал жуулчлал болон соёлын үр дүнг харуулсан хэсэг



Хэрэглэгчийн судалгааны дүгнэлт

Нэгдүгээрт, судалгаанд оролцогчдын 91.7% нь уламжлалт элемент агуулсан хурим хийхийг хүсэж байгаа нь уламжлалт хуримын үйлчилгээнд нийгмийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг тодорхой баталж байна.

Хоёрдугаарт, иргэдийн уламжлалт хурим хийж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь зан үйл, ёс заншлын мэдлэг дутмаг байдал (33%) болон мэргэшсэн зохион байгуулагч байгууллагын хомсдол (26.2%) байгаа нь тодорхой болсон бөгөөд энэ нь тухайн үйлчилгээний салбарт бизнесийн тодорхой нааштай орон зай оршиж байгааг харуулж байна.

Гуравдугаарт, уламжлалт хурим зохион байгуулах мэргэшсэн компанийг дэмжих хандлагатай иргэдийн хувь 97.2% хүрч байна. Ихэнх иргэд гэр, хувцас, хоол, ёслол бүгдийг нэг дороос шийдэх бүрэн үйлчилгээний багцыг (74.1%) болон зааварчилгааны дэмжлэгийг (55.6%) хамгийн их хүсэж байгаа нь бизнесийн загварыг боловсруулахад тодорхой чиглэл болж байна.

Дөрөвдүгээрт, оролцогчдын 75.3% нь уламжлалт монгол хурим гадаадын жуулчдад сонирхолтой байж болно гэж үзсэн бөгөөд 73.2% нь уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгох нь монгол соёлыг сурталчлахад чухал буюу маш чухал гэж дэмжсэн нь соёлын аяллын бүтээгдэхүүн болгох боломж бодитоор оршиж байгааг харуулж байна.

Тавдугаарт, нийт оролцогчдын 95.3% нь уламжлалт зан үйлийг үр хойчдоо дамжуулах нь чухал буюу маш чухал гэж үзсэн нь иргэдийн дунд соёлын өвийг хадгалах, дамжуулах хүсэл эрмэлзэл нийгэмд хүчтэй байгааг баталж байна.

Эдгээр үр дүнгийн нийлбэр дүгнэлтээр авч үзвэл уламжлалт монгол хурим болон зан үйлийг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх нь нийгмийн хэрэгцээ болон иргэдийн хандлага, хүслийн хувьд бүрэн нийцэж байгаа бөгөөд соёлын өвийг хадгалах, олон улсад таниулах, бизнесийн боломжийг хөгжүүлэх цогц зорилтыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх боломжтой гэдгийг тодорхой баталж байна.

Зураг 2.22 Монгол хуримын хөтөлбөрийн дэлгэрэнгүй



ДУГНЭЛТ

Судалгааны таамаглалтай харьцуулан дүгнэхэд:

Нэгдүгээр таамаглал батлагдсан. Оролцогчдын 91.7% нь уламжлалт элемент агуулсан хурим хийхийг хүсч байгаа нь хэрэглэгчийн эрэлт бодитоор оршиж байгааг нотолж байна.

Хоёрдугаар таамаглал мөн батлагдсан. Дэлхийн destination wedding зах зээл 12.7–17.3%-ийн жилийн дундаж өсөлтийн хурдтайгаар өсч байгаа бөгөөд Ази-Номхон Далайн бүс тэргүүлж байгаа нь Монгол Улсын байршлын давуу талтай нийцэж байна.

Гуравдугаар таамаглал баталгаажсан. Мэдлэгийн дутагдал (33%) болон мэргэшсэн байгууллагын хомсдол (26.2%) нь хамгийн том саад болж байгааг судалгааны үр дүн нотолж байна.

Гэсэн хэдий ч судалгааны хязгаарлалтын хувьд туршилтын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бодит кейс хэрэгжүүлэлт хийгдээгүй байгаа нь цаашдын судалгааны чиглэл болж байна. Хөтөлбөрийн загвар нь онол-практикийн хосолсон таамаглал бөгөөд зах зээлийн жинхэнэ туршилтаар нотлогдоогүй тул гүйцэтгэлийн шинжилгээ (pilot testing) дараагийн судалгааны тэргүүлэх чиглэл болно.

Уламжлалт зан үйл, ялангуяа Монгол хурим нь аялал жуулчлалын өвөрмөц бүтээгдэхүүн болгон хөгжих өндөр боломжтой. Энэ нь соёлын дархлааг дэмжих, олон улсын сонирхлыг татах, орон нутгийн эдийн засгийг сайжруулах давуу талтай.

Гэвч ийм бүтээгдэхүүнийг хөгжүүлэхдээ жинхэнэ уламжлалт утгыг хадгалах, оролцогчдын зөвшөөрөл, ёс зүйн зарчим, соёлын мэдлэгт суурилсан тайлбар, чанартай үйлчилгээний стандартыг хослуулах шаардлагатай. Монгол хуримыг аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх нь зөвхөн бизнесийн асуудал биш, харин соёлын өвийг хойч үедээ таниулах чухал арга зам юм.

ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүнгээс гарсан зөвлөмжийг гурван түвшнээр буюу бодлогын түвшин, байгууллагын түвшин, хэрэглэгчийн түвшин зэрэг дараах үе шаттай хэрэгжүүлэх боломжтой байдлаар танилцуулж байна.

1. Богино хугацааны зөвлөмж (0-1 жил) -Туршилтын үе шат

- Аяллын компанид:

Эхний ээлжинд нэг өдрийн "А:Үндсэн" хөтөлбөрийн туршилтын хэрэгжүүлэлтийг 10–20 оролцогчтойгоор явуулж, зочдын сэтгэл ханамж, зан үйлийн ойлголт, тайлбарын чанарыг хэмжих. Туршилтын үр дүнд тулгуурлан гурван өдрийн хөтөлбөрт шилжих.

- Хос, гэр бүлд:

Хурмаа төлөвлөхөөсөө өмнө ахмадуудаас зан үйлийн зааварчилгаа авч, хоёр талын гэр бүлийн ахмадуудыг ёслолд идэвхтэй оролцуулах. Орчин үеийн элементийг уламжлалт ёслолын дараа нэмэлт байдлаар оруулах.

2. Дунд хугацааны зөвлөмж (1-3 жил) -Стандартчилал ба өргөтгөл

- Аяллын байгууллагад:

Монгол хуримын аяллын үйлчилгээний стандарт, хөтөлбөрийн гарын авлага, хуримын хөтчийн сертификатын сургалтыг боловсруулж, мэргэшсэн хүний нөөцийг бэлдэх. Олон улсын платформ (Airbnb Experiences, Culture Trip, GetYourGuide)-д бүтээгдэхүүнийг бүртгүүлж, Солонгос, Япон, Баруун Европын зах зээлд чиглэсэн маркетинг эхлүүлэх.

- Засгийн газар, бодлогын байгууллагад:

"Монголд зочлох жил 2023-2028" хөтөлбөрт уламжлалт хуримын аяллыг тусгай бүтээгдэхүүний сегмент болгон оруулах. ЮНЕСКО-ийн биет бус соёлын өвийн стандарттай нийцсэн зан үйлийн аяллын хэрэгжүүлэх дүрэм журмыг боловсруулах.

3. Урт хугацааны зөвлөмж (3-с дээш жил) -Тогтвортой хөгжлийн үе шат

- Салбар хоорондын хамтын ажиллагаанд:

Орон нутгийн малчид, уламжлалт зан үйлийн мэргэжилтнүүд, аяллын компаниуд, их дээд сургуулийн судалгааны байгууллагуудыг нэгтгэсэн хамтын зохион байгуулалтын сүлжээ бий болгох. Жил бүрийн үр дүнгийн тайлан гарган, зан үйлийн утга агуулгыг алдагдуулахгүй байх мониторинг хийх.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээрх

- 1.(2025 оны 2 17). Inside Mongolia: <https://www.insidemongolia.mn/post/kkIIWs83Ho3>
- 2.(2025 оны 4 10). Үндэсний статистикийн хороо: <https://www.1212.mn>
- 3.(2023 оны 4 7). Хурган арьсан дотортой Даллагын уут. Улаанбаатар хот.
- 4.(2026 оны 2 14). Шагайн уут. Улаанбаатар.
- 5.(2016 оны 3 7). Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг урамшуулахад 100 САЯ ТӨГРӨГ зарцуулна. ikon.mn: <https://ikon.mn/n/orf>
- 6.Алтанзагас, П. (2023 оны 4 6). “Хуримын үзэсгэлэн-2023” зохион байгуулагдана. Ubn.mn: <https://ubn.mn>
- 7.Бадамгарав, Б. (2022 оны 3 25). "Хосууд нэгэндээ үнэнч байгаагүй бол амьдралаасаа урвасан хэмээн хүндээр хүлээж авдаг. Тиймдээ ч салалтын нэг шалтгаан болдог". ikon.mn: <https://ikon.mn/opinion/2i1v>
- 8.Боловсрол, с. ш. (2019 оны 11 29). Соёлын өвийн үндэсний төв: <https://ncch.gov.mn/ich?ItemID=3>
- 9.Брэнд Медиа Групп. (2021). Бидний тухай. <http://khurim.mn/>: <http://khurim.mn>
- 10.Буяннэмэх, Б. (2025 оны 12 16). Mongolian Journals of Arts and Culture. Mongolian Journals Online: <https://www.mongolajol.info/index.php/MJAC/article/view/5241>
- 11.Гэр бүл, (2025 оны 11 24). <https://mlsp.gov.mn>
- 12.Гэрлэх ёслолын ордон. (2026). Гэрлэх ёслолын үйлчилгээ. www.weddingpalace.mn: <https://www.weddingpalace.mn/service/wedding/>
- 13.Мирим консулт. (2019). Аялал жуулчлал. Улаанбаатар: MIRIM.
- 14.Мондакт. (2025). Бидний тухай. Monduct mongolian product LLC: <https://www.monduct.mn/home>
- 15.Монголын эвент хуримын үйлчилгээний компани. (2026 оны 5 18). ТАНЫ МӨРӨӨДЛИЙН ХУРИМЫГ. Улаанбаатар.
16. Монгол хэлний их тайлбар толь. (2016). хайсан үгийн нэр. Монгол хэлний их тайлбар толь: <https://www.mongoltoli.mn/dictionary/detail/95355>
- 17.Монгол хэлний их тайлбар толь. (2016). хайсан үгийн нэр. mongoltoli.mn: https://www.mongoltoli.mn/search.php?opt=1&rating=up&ug_id=886
- 18.Жуулчдын мэдээллийн төв. (огноо байхгүй). Монгол гэр барих дараалал
- 19.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл, урлагийн газар. (2017 оны 10 18). Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл. culture.gov.mn: <https://culture.gov.mn/index.php/home/tv/soyol-soyliin-uv/tusul-hutulbur/387>

20. Найр энтертайнмент. (2026). Нүүр. Найр энтертайнмент:
<https://nair.mn/services/khurim>
21. Намжил, Т. (2014). Монгол гэр бүл. Улаанбаатар: Гэр бүл судлалын төв.
22. Нандинбилиг, Г. (2020). Монгол соёл иргэншил судлал. Улаанбаатар: МУИС Пресс
 Хэвлэлийн газар.
23. Номин, Г. (2021 оны 3 8). ikon: <https://ikon.mn/>
24. Одбагмэд, З. (2001). Монгол ардын хүндлэх, мэндлэх, талархах, зэмлэх, хориглон
 цээрлэх ёсон. Улаанбаатар: Ш.Отгонбилэгийн нэрэмжит технологийн сургууль.
25. Өмнөговь. (2026 оны 2 13).
26. Сампилдэндэв, Х; Уртнасан, Н; Дорждагва, Т. (2006). Монгол зан үйл, баяр ёслолын
 товчоон. Улаанбаатар хот: Бемби Сан.
27. Содон хурим. (2026 оны 2 13). Хуримын хөтөлбөр. Улаанбаатар.
28. Сүхбат, Ш. (2013). Монгол хүн гэр бүл, ёс заншил. Улаанбаатар хот: Мөнх дардас.
29. Скайресорт. (2025). Event. Sky resort: <https://skyresort.mn>
30. Үндэстэн. (2025 оны 5 8). Гал тахиx ёс ба өдөр. undesten.mn:
<http://undesten.mn/171684.html>
31. Үйлдвэр, Ц. С. (огноо байхгүй). Gerege shop.
32. Үйлчилгээ. (огноо байхгүй). Гэрлэх ёслолын ордон: weddingpalace.mn
33. Хорлоо, П. (1999). Монгол ардын зан үйлийн хэлхээ. Улаанбаатар хот: Хэл
 зохиолын хүрээлэн.
34. ХХК, (2016). Аялал жуулчлалын салбарын нийслэлийн нийгэм, соёлд үзүүлэх
 нөлөөллийн судалгааны тайлан. <https://mirim.mn>
35. Хүрээ сайт. (2024 оны 1 17). Бэр гуйх ёсон. huree.mn:
[https://huree.mn/%D0%B1%D1%8D%D1%80-
%D0%B3%D1%83%D0%B9%D1%85-%D1%91%D1%81%D0%BE%D0%BD/](https://huree.mn/%D0%B1%D1%8D%D1%80-%D0%B3%D1%83%D0%B9%D1%85-%D1%91%D1%81%D0%BE%D0%BD/)
36. Хүрээ сайт. (2025). Монгол Шилтгээн. huree.mn: <https://huree.mn/>
37. Шангри-Ла 2026). Wedding Packages. www.shangri-la.com: [https://www.shangri-
la.com/ulaanbaatar/shangrila/weddings-celebrations/wedding-packages/](https://www.shangri-la.com/ulaanbaatar/shangrila/weddings-celebrations/wedding-packages/)
38. Энтертайнмент. (2026 оны 5 12). Хуримын шинэлэн хөтөлбөр найруулга.
 Entertainment.mn: [https://doc.clickup.com/3732411/p/h/3hwxv-
12438/93c9a342411ea5a](https://doc.clickup.com/3732411/p/h/3hwxv-12438/93c9a342411ea5a)
39. Энхбат, Б. (2023 оны 6 8). Аялал жуулчлалын ирээдүй: Өв соёлоо алдаршуулж,
 онгон байгалиа хамгаалах нь. Unread.tm: [https://unread.today/c/2030-sustainable-
tourism](https://unread.today/c/2030-sustainable-tourism)
40. Энхболд, Б. (2022). Зан үйл (Behavior). ХҮНИЙ ЭРХ онол, арга зүйн сэтгүүл, 34.


Гадаад хэлээрх

- 1.(n.d.). Retrieved from toolsmasteruk co uk.
- 2.Cohen, E. Authenticity and Commoditization in Tourism.
- 3.DataIntelo. (2024). Destination Wedding Tourism Market Research Report 2033. Retrieved from DataIntello Market Intelligence.
- 4.Group, I. (2024).
- 5.Group, I. (2024). Global Destination Wedding Market. Retrieved from Statistics and Forecast 2025-2033: IMARC Group Research
- 6.MacCannell, D. The Tourist.
- 7.Research, D. B. (2024). Global Destination Wedding Market Size, Share and Trends Analysis to 2032. Retrieved from FMI Research.
- 8.Smith, V. Hosts and Guests: The Anthropology of Tourism.
- 9.Statistics, G. D. (2024). IMARC Group.
- 10.UN Tourism. Cultural Tourism Reports.
- 11.UNESCO. Intangible Cultural Heritage.
- 12.UNWTO. (2024). Sustainable Tourism Indicators. Retrieved from United Nations World Tourism Organization.
- 13.VARNIYA. (2025). Destination Wedding Cost in India: Budget Breakdown and Expert Tips. Retrieved from VARNIYA Research Blog.


ХАВСРАЛТ

Хавсралт А Судалгааны асуулга


1. Таны хүйс
109 responses




2. Таны нас
109 responses




3. Таны гэрлэлтийн байдал
109 responses



4. Та одоо хаана амьдардаг вэ?
109 responses




5. Та хурим хийхдээ ямар хэлбэрийг илүүд үзэх вэ?
109 responses




6. Уламжлалт хурим хийхийг хүсэх гол шалтгаан юу вэ? (Нэгээс олон хариулт сонгож болно)

107 responses




7. Уламжлалт хурим хийхгүй байх гол шалтгаан юу вэ? (Нэгээс олон хариулт сонгож болно)

103 responses




8. Та уламжлалт үндэсний хуримын ёс заншлыг хэр сайн мэддэг вэ?

109 responses




9. Уламжлалт хурим хийхэд хамгийн чухал гэх зүйл (Нэгээс олон хариулт сонгож болно)


108 responses




10. Хэрвээ уламжлалт хурим зохион байгуулах мэргэшсэн компани байвал та дэмжих үү?
109 responses




11. Та уламжлалт хурим зохион байгуулах компаниас юуг хамгийн их хүсэх вэ? (Нэгээс олон хариулт сонгож болно)
108 responses



12. Та уламжлалт хурим зохион байгуулахад нийт хэдийг зарцуулах боломжтой гэж үзэх вэ?
109 responses




13. Та хэчнээн зочин урих вэ?
108 responses




14. Уламжлалт хурим нь гадаадын жуулчдад сонирхолтой байж болно гэж та бодож байна уу?

109 responses



15. Уламжлалт зан үйлийг аяллын бүтээгдэхүүн болгох нь монгол соёлыг сурталчлахад хэрэгтэй гэж үзэж байна уу?

108 responses



16. Та уламжлалт зан үйлийг үр хойчдоо дамжуулах нь чухал гэж үзэх үү?

108 responses

